**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ /2023.12.10/**
**/Жилийн эцсээр/**

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв /сая.төг/ | Хариуцах нэгж | Биелэлт | хшү |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Зорилт 1 Эрх зүйн болон хөгжлийн бодлогын баримт бичиг тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангана.** | | | | | |
| Автотээврийн салбарын хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Шинэ сэргэлтийн бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр, Салбарын сайд болон ТӨБЗГ-ын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр | | | | | |
| 1.1 | 1.1.1. Дээд газрын тогтоол шийдвэр, салбарын яамнаас гаргасан тушаал, шийдвэр, яамны удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тайлагнах<br>**Шалгуур үзүүлэлт:**<br>Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа:**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>Үүрэг даалгаврын хэрэгжилт 50-аас доошгүй хувь хангагдсан байна.<br>**2-р улиралд:**<br>Үүрэг даалгаврын хэрэгжилт 70-аас доошгүй хувь хангагдсан байна.<br>**3-р улиралд:**<br>Үүрэг даалгаврын хэрэгжилт 80-аас доошгүй хувь хангагдсан байна.<br>**4-р улиралд:**<br>Үүрэг даалгаврын хэрэгжилт 90-ээс дээш хувь хангагдсан байна. | - | ЗСХНХ | Тус үйлдвэрийн газарт дээд газрын 5 тогтоол шийдвэрээр нийт 26 үүрэг даалгавар өгөгдсөнөөс ЗТХЯ-ны ХШҮДАГ-аас 23 үүрэг даалгаврыг 100% хэрэгжсэнд тооцож, хяналтаас хассан бөгөөд 3 үүрэг даалгавар хэрэгжилтийн шатанд байна.<br>Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тус үйлдвэрийн газарт өгсөн 3 үүрэг даалгаврын хэрэгжилтийг гаргаж, ЗТХЯ-нд 2023.03.24-ний өдрийн 1/358 тоот эхний хагас жилийн байдлаар 2023.06.23-ны өдрийн 1/862 тоот албан бичгээр тус тус хүргүүлж, хэрэгжилт үр дүнг тайлагнасан.<br>Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны III улирлын байдлаар нэгтгэн гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2023.09.22-ны өдрийн 1/1230 тоот албан бичгээр, жилийн эцсийн байдлаар 2023.12.15-ны өдрийн дотор хүргүүлэхээр ажиллаж байна. /Хугацаа болоогүй./ | |
| | 1.1.2 “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан Автотээврийн үндэсний төвөөс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, улирал бүр яаманд тайлагнах<br>**шалгуур үзүүлэлт**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>Зорилтот түвшин<br>**1-р улиралд:**<br>2023 оны зорилтот ажлуудын биелэлт 50-аас доошгүй хувь хангагдсан байна.<br>**2-р улиралд:**<br>2023 оны ажлуудын биелэлт 70-аас доошгүй хувь хангагдсан байна.<br>**3-р улиралд:** | - | ЗСХНХ | “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-т тусгагдсан Автотээврийн үндэсний төвөөс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг II улирлын байдлаар гарган 2023.06.15-ны өдрийн 1/799 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлсэн. III улирлын байдлаар 2023.09.28-ны өдрийн 1/1247 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар 2023.12.15-ны өдрийн дотор хүргүүлэхээр ажиллаж байна. /Хугацаа болоогүй./ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2023 оны ажлуудын биелэлт 80-аас доошгүй хувь хангагдсан байна.<br>**4-р улиралд:**<br>2023 оны зорилтот ажлуудын биелэлт 90-ээс доошгүй хувь хангагдсан байна. | | | | |
| | 1.1.3 Авлигын шалтгаан, нөхцөлийг судлан тогтоох, тэдгээрийг арилгах, авлигыг таслан зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлэх.<br>Шалгуур үзүүлэлт:<br>Судалгаа хийж, зөвлөмж авсан тоо<br>Хугацаа:<br>I-IV улирал<br>Зорилтот түвшин:<br>**1-2-р улиралд:**<br>Үйлдвэрийн газрын ажилтан, албан хаагчидтай холбогдон гарсан авлигын шалтгаан нөхцөлийн талаар судалгаа хийсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээний талаар АТГ-аас зөвлөмж авч, холбогдох нэгжид хүргүүлсэн байна.<br>**4-р улиралд:**<br>Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан байна | - | ЗСХНХ | 2023 оны 4-р сард Авлигын шалтгаан, нөхцөлийг тодорхойлох суурь судалгааг нийслэл болон 21 аймгийн автотээврийн төвийг хамруулан 500 үйлчлүүлэгч, 290 ажилтан буюу нийт 790 иргэнээс авч ажилласан бөгөөд авлигыг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар судалгааны арга зүй, дүгнэлтийг удирдлагад танилцуулсан.<br>Судалгааны үр дүнд ДОТООД шударга байдлын үнэлгээ 97 гарсан. Үүнд судалгаанд хамрагдсан ажилтан, албан хаагчдын 86 хувь буюу 257 нь авлигад өртдөг байдлыг тодорхойлох асуултуудад тус бүр “Огт үгүй” гэсэн хариултыг өгснөөр үнэлгээнд нөлөөлсөн байна. ГАДААД шударга байдлын үнэлгээ 92 гарсан үр дүнд “Албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө танаас нэмэлт төлбөр авах тохиолдол гарч байсан эсэх”, “Албан үүргээ гүйцэтгэснийхээ төлөө танаас нэмэлт төлбөр авахыг хүссэн /шаардсан/ тохиолдол гарч байсан эсэх”-ийг тодруулахад дийлэнх хувь буюу 344 үйлчлүүлэгч “Огт үгүй” гэсэн хариултыг өгсөн нь нөлөөлсөн.<br>Үйлдвэрийн газрын дотоод болон гадаад шударга байдлын үнэлгээний дундаж үзүүлэлт буюу “ЕРӨНХИЙ ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ”-г тооцож үзэхэд 94.5 байгаа нь улсын дунджаас 1.3 пунктээр илүү байна.<br>Авлигын шалтгаан нөхцөлийг тодруулахад дараах хариултыг өгсөн. Үүнд:<br>✓ Хувь хүний ёс зүйгүй байдал<br>✓ Цалин хөлс бага,<br>✓ Албан тушаал эрх мэдлээ урвуулан ашигладаг байдал,<br>✓ Удирдах албан тушаалтны нөлөө,<br>✓ Найз нөхөд, хамаатан, хамтран ажиллагсдын нөлөө,<br>✓ Хүнд суртал,<br>✓ Төрийн үйлчилгээ удаан, цаг хугацаа их шаарддаг гэх мэт.<br>Мөн авлигыг бууруулах, арилгах дараах арга хэмжээг санал болгосон байна. Үүнд:<br>✓ Цалин хөлс нэмэгдүүлэх,<br>✓ Ил тод байх,<br>✓ Ажилтан, албан хаагчийн ёс зүйг сайжруулах,<br>✓ Төрийн үйлчилгээг цахимжуулах,<br>✓ Удирдах албан тушаалтны нөлөөг бууруулах,<br>✓ Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах,<br>✓ Хувь хүний хөгжил, авлигын мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт хийх, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ✓ Авлига авсан, өгсөн хүнд хатуу хариуцлага тооцох,<br>✓ Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах,<br>✓ Хуулийн хэрэгжилт, зохицуулалтыг сайжруулах гэх мэт. | |
| | 1.1.4 Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд Авлигын эрсдэлийн үнэлгээ хийх.<br>Шалгуур үзүүлэлт<br>Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд АТГ-аас эрсдлийн үнэлгээ хийгдсэн<br>Хугацаа<br>III улирал<br>Зорилтот түвшин<br>**3-р улиралд:**<br>Эрсдлийн үнэлгээний асуулга гарган,<br>Үйлдвэрийн газрын зарим, хэлтэс, салбар, төвийн үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийсэн байна. | - | ЗСХНХ ХЭЗТ | Үйлдвэрийн газрын 2022 оны болон 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд тулгуурлан судалгаа хийж, судалгааны арга зүй, дүгнэлтийг удирдлагад танилцуулсан мөн Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Судалгааны арга зүй, дүгнэлт болон үйлдвэрийн газрын хүсэлтийн хүрээнд Авлигатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтсээс "Авлигын эрсдэлийн үнэлгээ" -г тус үйлдвэрийн газрын төв байранд 2023.11.01-ний өдрөөс байрлан хийж байгаа бөгөөд эрсдэлийн үнэлгээний ажил одоогоор дуусаагүй үргэлжилж байна. /Хугацаа болоогүй./ | |
| | 1.1.5 Салбарт мөрдөж буй олон улсын гэрээ, хэлэлцээрийг байгууллагын цахим хуудсанд байршуулах.<br>Шалгуур үзүүлэлт<br>Байршуулсан хэлэлцээрийн тоо<br>Хугацаа<br>II улирал<br>Зорилтот түвшин<br>**2-р улиралд:**<br>АТБХЗГ олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон хэлэлцээрийн судалгаа авах, байгууллагын цахим хуудсанд авто тээврийн салбарын хэлэлцээрийг байршуулсан байна. | - | ЗСХНХ ХЭЗТ | Тайлант хугацаанд Засгийн газар хоорондын хэлэлцээрийг тухай бүрт нь байршуулж ажилласан. Холбогдох линкийг хавсаргав.<br>**https://www.transdep.mn/post.php?p=5164**<br>Тайлан, мэдээ нь тухайн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хүрсэн үр дүн, гүйцэтгэсэн ажлын чанарыг бүрэн тодорхой илэрхийлсэн. | |
| | 1.1.6 Монгол бичгийн сургалтыг үе шаттай зохион байгуулах<br>Шалгуур үзүүлэлт<br>Сургалтад хамрагдсан албан хаагчдын эзлэх хувь<br>Хугацаа<br>I-IV улирал<br>Зорилтот түвшин<br>**1-р улиралд:**<br>Ажилтнуудаас монгол бичгийн түвшин тогтоох шалгалт авсан байна.<br>**2-р улиралд:**<br>Анхан шатны сургалт зохион байгуулсан байна.<br>**3-р улиралд**: Дунд шатны сургалт зохион байгуулсан байна.<br>**4-р улиралд:** Төв албаны сургалтад хамрагдах шаардлагатай ажилтнууд 100% хамрагдсан байна | 4,5 сая.төг | ЗСХНХ | Чой.Лувсанжавын нэрэмжит "Хэл иргэншлийн академи"-тэй хамтjан монгол бичгийн анхан болон дунд түвшний мэдлэг олгох сургалтад 100 ажилтанг хамруулан сургаж байна. | |
| | 1.1.7 Автотээврийн салбарын ажил үйлчилгээнд нэвтрүүлж болохуйц инновацын шинэ санал санаачлага гаргах<br>Шалгуур үзүүлэлт<br>Инновацийн тоо<br>Хугацаа | - | АТХ, **ЗТХ**, ХУХ | ЗТХ- Жуулчин тээврийн захиалгат үйлчилгээ үзүүлэх апп нэвтрүүлэх санал санаачлагыг гарган холбогдох тооцоо судалгааг хийн МТХ-тэй хамтран байгууллагын autobox.mn дээр байршуулахаар ажиллаж байна. Байгууллагын 2020 оны Инновацийн чиглэлд Нэгдүгээр байрт орсон "Хөгжлийн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | I-IV улирал<br>Зорилтот түвшин<br>**1-4-р улиралд:** Салбарын хэмжээнд үр нөлөө, үр ашигтай 2-оос доошгүй инновацийн шинэ санал санаачлага гаргасан байна. | | | бэрхшээлтэй иргэнд үйлчлэх тусгай ажилтан бэлтгэх” төслийн хүрээнд ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар“-тай хамтран 2023.12.13-ний өдөр цахим хэлбэрээр сургалт зохион байгуулсан. Уг сургалт нь ХБИ гэж яг ямар хүнийг хэлэх вэ?, ХБИ-тэй хэрхэн харьцах вэ?, ХБИ-ний хөдөлмөр эрхлэлт, ХБИ-ний оффис байр, байгууламжийг хэрхэн төлөвлөх вэ? гэсэн 4 агуулгаар зохиогдсон ба сургалтад тус үйлдвэрийн газрын 67 ажилтан, албан хаагчид хамрагдсан. Мөн тус агентлагтай хамтран сургалтад хамрагдсан ажилтнуудад дохионы хэлний анхан шатны сургалт автобуудлын төлөвлөлтүүдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулагдсан байдлаар шийдвэрлэж практик зөвлөгөөг авч байна.<br>АТХ: Тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг цахимжуулах төсөл судалгааг боловсруулан танилцуулга бэлтгэж ЗТХЯ-ны АТБХЗГ-т 2023.03.20-ны өдөр цахимаар хүргүүлсэн. Байгууллагын autobox.mn апилекшин хийж байгаатай холбогдон тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг цахимжуулах ажил түр хойшлогдсон.<br>**ХУХ:** Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн багийн ажлын тухай Европын хэлэлцээрийн хүрээнд ЗТХЯ-аас батлагдсан төлөвлөгөөний дагуу Хяналтын нэгдсэн системд тахографын төхөөрөмж холбох, мэдээлэл солилцох боломжийг судлан ажиллаж байна. | |
| | 1.1.8 Автотээврийн салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах<br>Шалгуур үзүүлэлт<br>Хэлэлцээрт тусгагдсан асуудлын хэрэгжилт<br>Хугацаа<br>I-IV улирал<br>Зорилтот түвшин<br>**1-р улирал:** Хэлэлцээрийг нийт ажилтнуудад таниулж, дотоод сүлжээнд байршуулсан байна.<br>**2-3-р улирал:** Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан байна.<br>**4-р улирал:** Хэлэлцээрийн хэрэгжилтийг гаргаж, ажил олгогч болон ажилтнуудад танилцуулсан байна | | ЗСХНХ<br>ҮЭХ | Зам, тээврийн хөгжлийн сайд, Монголын тээвэр холбоо газрын тосны ажилтны ҮЭ-үүдийн холбооны дарга, Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал нарын хамтран байгуулсан “Автотээврийн салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хамтын хэлэлцээр”-ийг үйлдвэрийн газрын үйлдвэрчний хорооны гишүүдэд дотоод сүлжээний захидлаар болон цахимаар танилцуулсан.<br>Мөн Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн найруулсантай холбогдуулан Үйлдвэрийн газар болон Үйлдвэрчний эвлэлийн хороо хоорондын хамтын гэрээг шинэчлэн батлуулахаар гэрээний төсөлд гишүүдээс санал авч тусгасан.<br>Гэрээний төслийг ажил олгогчид 2023.05.09-ний өдрийн 02 тоот албан бичгээр хүргүүлж саналыг тусгуулан гэрээг байгуулсан. | |
| | 1.1.9 Автотээврийн салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээлэл, сургалтын нэгдсэн системд үйлдвэрийн газрын ажилтан, албан хаагчдын болон тээвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийг оруулах, баяжуулах<br>Шалгуур үзүүлэлт<br>Зам тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/85 дугаар тушаалын хэрэгжилтийн хувь | - | ЗСХНХ<br>**ЗТХ**<br>АТХ | Автотээврийн салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээлэл, сургалтын нэгдсэн систем /org.teever-hr.mn/-д үйлдвэрийн газрын ажилтан, албан хаагчдын 80 гаруй хувь нь хувийн мэдээллээ оруулсан.<br>Мөн тус системд улс, хот хоорондын нийтийн тээврийн аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийг оруулахаар мэдээллийг бүрэн бэлтгэж дуусгасан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Хугацаа<br>I-IV улирал<br>Зорилтот түвшин<br>**1-2-р улиралд:** Үйлдвэрийн газрын нийт ажилтан, албан хаагчдын мэдээллийг оруулсан байна.<br>**3-4-р улиралд:** Тээвэрлэгч ААНБ-уудын мэдээллийг оруулж эхэлсэн байна. | | | Тус үйлдвэрийн газартай гэрээтэй хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 57 аж ахуйн нэгж, байгууллагуудын жолооч нарыг оролцуулсан уулзалт, хурлыг 2023.03.29-ний өдөр зохион байгуулсан бөгөөд уулзалтын үеэр org.teever-hr.mn апп-аас татан боловсруулсан гарын авлага болон Зам тээврийн салбарын хүний нөөцийн бүртгэл, мэдээлэл, сургалтын нэгдсэн систем"-ийг ашиглах талаарх зааврыг танилцуулсан.<br>2023.12.10-ний өдрийн байдлаар тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын хүний нөөцийн нийт 710 мэдээллийг бүртгэлжүүлсэн. | |
| **Зорилт 2: Байгууллагын захиргааны удирдлагын манлайллыг хангаж, хууль эрх зүйг боловсронгуй болгон, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулна.** | | | | | |
| Албан хаагчдын ажлын гүйцэтгэлд удирдлагаас байнгын хяналт тавьж, гүйцэтгэл, үр дүнг сайжруулахад шаардлагатай арга хэмжээг шуурхай шийдвэрлэж, зохион байгуулж ажиллах чиглэлээр | | | | | |
| 2.1 | 2.1.1 Үйлдвэрийн газрын 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг улирал бүр нэгтгэн боловсруулж, удирдлагад танилцуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тайлагнасан байдал<br>**хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-4-р улиралд:**<br>Үйлдвэрийн газраас хийсэн ажлын тайланг улирал бүр гаргаж, удирдлагад танилцуулж, мэдээллээр хангасан байна. | - | ЗСХНХ | Үйлдвэрийн газрын 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын товч тайланг нэгтгэн, нийт ажилтны тайлангийн хурал дээр, дэлгэрэнгүй тайланг 2023.12.25-ны өдрийн дотор удирдлагад танилцуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. | |
| | 2.1.2 Журмын дагуу үйлдвэрийн газрын нийт ажилтнуудын 2023 оны эхний хагас болон бүтэн жилийн тайланг хүлээн авч үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Үнэлэлт дүгнэлт өгсөн байдал<br>**Хугацаа**<br>II, IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**2-р улиралд:**<br>Үйлдвэрийн газрын нийт ажилтнуудын 2023 оны эхний хагас жилийн тайланг хүлээн авч үнэлэлт, дүгнэлт өгсөн байна.<br>**4-р улиралд:**<br>Үйлдвэрийн газрын нийт ажилтнуудын 2023 оны жилийн эцсийн тайланг хүлээн авч үнэлэлт, дүгнэлт өгсөн байна. | | ЗСХНХ | Тус үйлдвэрийн газрын 2018 оны нэгжийн удирдлага, ажилтны үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх А/334 дүгээр журмын дагуу нийт ажилтнуудын ажлын үнэлгээг хагас, бүтэн жилээр үнэлдэг бөгөөд 2023 оны эхний хагас жилийн үнэлгээг хийх 3/826 тоот албан бичгийг 2023.06.20-ны өдөр бүтцийн нэгжүүдэд хүргүүлсэн. Үнэлгээг 2023.06.26-ны өдрөөр талбар болгон хүлээн авч нэгтгэн удирдлагуудад танилцуулсан бөгөөд 2023 оны жилийн эцсийн ажилтнуудын үнэлгээг 2023.12.15-ны өдрийн дотор хүлээн авахаар мэдээллийг хүргүүлсэн. /Хугацаа болоогүй./ | |
| | 2.1.3 Байгууллагын Захирлын зөвлөлийн хуралдаан, Захирлын шуурхай зөвлөгөөнийг журамд заасны дагуу зохион байгуулж, биелэлтийг хангуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Хэрэгжилтийн хувь | - | ЗСХНХ | Тайлант хугацаанд Захирлын зөвлөл нийт 5 удаа хуралдаж, 20 асуудал хэлэлцэж, шийдвэрлэсэн.<br>Захирлын шуурхай зөвлөгөөн нийт 19 удаа хуралдаж, Захирлаас нэгжийн дарга нарт нийт 282 үүрэг даалгавар өгснөөс 2023.12.08- | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-4-р улиралд:** Захирлын зөвлөл болон шуурхай хуралдаанаас гарсан шийдвэр, үүрэг даалгаврыг албажуулж, холбогдох нэгжид хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан байна. | | | ны өдрийн байдлаар бүрэн хэрэгжиж хяналтаас хасагдсан 245, хэрэгжилтийн шатанд 70%-тай 16, удааширсан 21 үүрэг даалгавар байна.<br>Захирлын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг нэгтгэн боловсруулж, нэгжийн дарга нар болон холбогдох ахлах мэргэжилтэн, мэргэжилтнүүдэд хүргүүлж, биелэлтийг Хэлтсүүд, Улаанбаатар болон орон нутаг дахь тав салбаруудаас авч, нэгтгэн гаргаж, ХШДАА-нд хүргүүлэн ажиллаж байна. | |
| | 2.1.4 Захирлын тушаалын биелэлтийг нэгтгэн гаргаж, хяналт тавьж ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-4-р улиралд:** Тушаалын хэрэгжилт хангагдсан байна | - | ЗСХНХ | Захирлын тушаалын биелэлтийг нэгтгэн сар бүрийн 10-нд ХШДАА-нд хүргүүлсэн. 2023.12.12-ны өдрийн байдлаар захирлын тушаал нийт-739 үүнээс А тушаал -252, Б тушаал-487 гарсан байна. | |
| | 2.1.5 Үйлдвэрийн газрын ажилтнуудыг шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Шагналын тоо болон мэдээллийн сан бүрдүүлсэн байдал<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-4-р улиралд:**<br>Үйлдвэрийн газрын бүтцийн нэгжүүдээс тухайн онд төрийн болон салбарын шагналд нэр дэвших албан хаагчдын судалгааг нэгтгэж, удирдлагад танилцуулж, зохион байгуулалтын арга хэмжээ авна.<br>Шагналын мэдээллийн сан бүрдүүлнэ. | - | ЗСХНХ | Монгол Улсын тулгар төрийн 2232 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 817 жил, Ардын хувьсгалын 102 жил, МУ-д автотээврийн салбар үүсч хөгжсөний 98 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтнуудыг төрийн одон медаль, ЗГ-ын салбарын тэргүүний ажилтан шагнал, ЗТХЯ-ны Жуух бичиг, “АТҮТ” ТӨҮГ-ын Хүндэт өргөмжлөлөөр шагнасан. Үүнд:<br>-“Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-гоор: Р.Саруул Автотээвэрчдийн ахмадын хорооны зохион байгуулагч, Г.Нацагдорж ахмад тээвэрчин, О.Батхишиг ахлах мэргэжилтэн,<br>-“Алтан гадас” одонгоор шагнуулсан ажилтнууд:<br>Б.Гүрсоронзон захирал, Д.Хорлоо ахмад тээвэрчин, Б.Цэцэгмаа бүртгэлийн мэргэжилтэн, Д.Цэцгээ ахмад тээвэрчин, Ж.Эрдэнэчимэг Хэнтий аймгийн ахмад тээвэрчин, Т.Пүрэв-Очир Завхан аймгийн ахмад тээвэрчин, Н.Цэрэндулам Завхан аймгийн АТТ-ийн ахлах нягтлан бодогч,<br>- “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар: Ш.Байгальмаа лавлах үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, О.Баяраа Сонгинохайрхан ЗТТ-ийн тээвэр зохицуулагч, Д.Янжиндулам Говьсүмбэр аймгийн АТТ-ийн ахлах нягтлан бодогч,<br>-Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/191 дүгээр тушаалаар Монгол Улсын “Автотээврийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр: Н.Отгонсар авто үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Г.Батмөнх Баянзүрх ТХҮТ-ийн инженер, С.Зоригоо ахлах мэргэжилтэн, Г.Нарантуяа Орхон аймгийн АТТ-ийн үйлчлэгч, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | - Сангийн сайдын 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 129 дүгээр тушаалаар “Санхүү, банкны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр: Г.Урангуа эдийн засагч, С.Дунгаамаа Дархан-Уул аймгийн АТТ-ийн ахлах нягтлан бодогч,<br>- Сангийн сайдын 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 129 дүгээр тушаалаар “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр:<br>Г.Дуламханд ахлах нягтлан бодогч, Н.Баярмагнай ахлах нягтлан бодогч,<br>-Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/191 дүгээр тушаалаар ЗТХЯ-ны<br>“Жуух бичиг”-ээр:<br>Р.Ганзориг Сонгинохайрхан ТХҮТ-ийн инженер, Д.Түвшинтөгс Сонгинохайрхан ТХҮТ-ийн инженер, Г.Бямбасүрэн Сонгинохайрхан ТХҮТ-ийн инженер, Б.Гэрэлт-Од улс хоорондын ачаа тээвэр хариуцсан мэргэжилтэн, Э.Оюун-Эрдэнэ Баянгол ТХҮТ-ийн бүртгэл хяналтын ахлах мэргэжилтэн, Ч.Отгонтуяа Баянгол ТХҮТ-ийн үйлчлэгч, О.Ганчулуун Баянгол ТХҮТ-ийн инженер, Н.Доржжүгдэр лавлах үйлчилгээний мэргэжилтэн, Э.Халиун лавлах үйлчилгээний мэргэжилтэн, Ж.Дэвшил Хуулийн тасгийн мэргэжилтэн, Г.Өлзийжаргал Өмнөговь аймгийн АТТ-ийн тээвэр зохицуулагч, Б.Байгальмаа Өмнөговь аймгийн АТТ-ийн үйлчлэгч, Н.Энхмаа Дорнод аймгийн АТТ-ийн үйлчлэгч, Н.Тамир Дорнод аймгийн АТТ-ийн тээвэр зохицуулагч, Х.Отгонтөгс Сэлэнгэ аймгийн АТТ-ийн үйлчлэгч, Н.Одгэрэл Дорноговь аймгийн АТТ-ийн тээвэр зохицуулагч,<br>Ц.Золзаяа Орхон аймгийн АТТ-ийн тээвэр зохицуулагч, - Сангийн сайдын 2023.06.22-ны өдрийн 129 дүгээр тушаалаар<br>Сангийн яамны “Жуух бичиг”-ээр: Ч.Хашмагнай Сонгинохайрхан ЗТТ-ийн нягтлан бодогч, С.Мөнгөнцэцэг Сонгинохайрхан ЗТТ-ийн ахлах нягтлан бодогч,<br>-“Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын захирлын 2023.07.05-ны өдрийн А/152 дугаар тушаалаар “Хүндэт өргөмжлөл”-өөр:<br>Ц.Уранчимэг Баянгол ТХҮТ-ийн ахлах нягтлан бодогч,<br>Э.Эрдэнэбал Баянзүрх ТХҮТ-ийн техникч,<br>Б.Батзаяа Сонгинохайрхан ЗТТ-ийн тасалбар түгээгч,<br>Б.Загдхүү Сонгинохайрхан ЗТТ-ийн ачаа тээш хариуцсан ажилтан, Г.Доржнамжаа харуул, Д.Буяндэлгэр хүний нөөцийн мэргэжилтэн, Г.Мөнхтулга улс хоорондын ачаа тээвэр хариуцсан мэргэжилтэн,<br>Ц.Солонго бүртгэлийн мэргэжилтэн, Г.Сэлэнгэ бүртгэлийн мэргэжилтэн, Б.Даваадорж Архангай аймгийн АТТ-ийн дотоод | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | ажил, аж ахуй хариуцсан мэргэжилтэн, Б.Мөнххишиг Архангай аймгийн АТТ-ийн бүртгэлийн мэргэжилтэн, Ц.Оюунсүрэн Архангай аймгийн АТТ-ийн тасалбар түгээгч, Б.Мөнх-Эрдэнэ Архангай аймгийн АТТ-ийн тээвэр зохицуулагч, С.Ануужин Сэлэнгэ аймгийн АТТ-ийн тээвэр зохицуулагч, Э.Цэвэлдулаанаа Дархан-Уул аймгийн АТТ-ийн үйлчлэгч, М.Бямбажаргал Өмнөговь аймгийн АТТ-ийн үйлчлэгч, Д.Түвшинжаргал Өмнөговь аймгийн АТТ-ийн харуул-галч,<br>-ЗЦГ-ын “Осолгүй манлай жолооч” тэмдгээр: Б.Шинэбаяр жолооч,<br>-МАТНХолбооны “Манлай тээвэрчин” тэмдгээр: Л.Отгонбаяр Баянгол ТХҮТ-ийн техникч,<br>-МЗХолбооны “Тэргүүний залуу” хүндэт тэмдгээр: Ч.Жамбалжав Баянгол ТХҮТ-ийн инженер тус тус шагнасан. | |
| | 2.1.6 Үйлдвэрийн газрын бүтцийн нэгжүүдээс хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 оны баримт бичгийг архивт бүртгэн хүлээн авах, архивын нэгж болгон хадгалах, лавлагаа, мэдээллийн сан бүрдүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Архивын бүрдэл<br>**Хугацаа**<br>I улирал<br>**Зорилтот түвшин**<br>1-р улиралд: Холбогдох баримт бичгүүдийг архивт хүлээн авсан байна. | - | ЗСХНХ | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 оны нийт-148 хадгаламжийн нэгжийг архивт хүлээн авч архивласан. | |
| | 2.1.7 Үйлдвэрийн газрын захирлын эрхлэх асуудлын хүрээнд гарсан эрх зүйн маргааныг шүүх, хууль хяналтын байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлдвэрийн газрын захирлын итгэмжлэл олгосноор төлөөлөн оролцох, үр дүнг тайлагнах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тайлагнасан байдал<br>**Хугацаа**<br>II, IV-р улирал<br>**Зорилтот түвшин**<br>2, 4-р улиралд: Судалгаа гаргаж, захиралд танилцуулсан байна. | - | ЗСХНХ | Үйлдвэрийн газрын захирлын эрхлэх асуудлын хүрээнд гарсан эрх зүйн маргааныг шүүх, хууль хяналтын байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлдвэрийн газрын захирлын итгэмжлэл олгосноор төлөөлөн оролцож байна.<br>2023 он гарснаар нийт 19 хэрэг маргаанаас 13 хэрэг маргаан нь шүүхийн эцсийн шатанд дууссан байна. Бусад хэрэг маргаан нь хуулийн хугацаагаар шийдвэрлэгдэнэ. /Хугацаа болоогүй./ | |
| | 2.1.8 Үйлдвэрийн газрын тухайн жилд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Батлагдсан байдал<br>**Хугацаа**<br>I улирал<br>**Зорилтот түвшин**<br>1-р сард: Үйлдвэрийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, удирдлагуудад танилцуулж, захирлаар батлуулсан байна. | - | ЗСХНХ | Үйлдвэрийн газрын 2023 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, захирлаар батлуулсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2.1.9 Үйлдвэрийн газрын удирдах ажилтнуудын зөвлөгөөн зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Зөвлөгөөн зохион байгуулагдсан байдал<br>**Хугацаа**<br>I улирал<br>**Зорилтот түвшин**<br>1-р улиралд: Зөвлөгөөн зохион байгуулагдсан байна. | - | ЗСХНХ<br>СЭЗХ | Үйлдвэрийн газрын удирдах ажилтны зөвлөгөөнийг 2023.02.09-10-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан бөгөөд нийт 44 удирдах ажилтан тус зөвлөгөөнд оролцсон.<br>Тус зөвлөгөөнөөр бүтцийн нэгжүүдийн дарга нарын тайланг сонсон, цаашид хийж гүйцэтгэх ажлын талаар үүрэг даалгавар өгч, санал солилцсон бөгөөд зөвлөгөөний мөрөөр авч хэрэгжүүлэх 01 тоот албан даалгаврыг 2023.03.10-ны өдөр бүтцийн нэгжүүдэд хүргүүлсэн. | |
| Байгууллагын ил тод байдлыг хангах, үйлдвэрийн газрын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах чиглэлээр | | | | | |
| 2.2 | 2.2.1 Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах, мэдээлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV Улирал<br>**Шалгуур үзүүлэлт**<br>**1-2-р улиралд:**<br>Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдлын хэрэгжилт 80-аас дээш хувь хангагдсан байна.<br>**3-4-р улиралд:**<br>Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдлын хэрэгжилт 90-ээс дээш хувь хангагдсан байна. | - | ЗСХНХ | “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн биелэлтийг 2023 оны I улирлын байдлаар нэгтгэн гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2023.03.24-ний өдрийн 1/359 тоот албан бичгээр, хагас жилийн байдлаар 2023.06.21-ний 3/844 тоот албан бичгээр тус тус хүргүүлж тайлагнасан.<br>“Ил тод байдлыг илтгэх 98 шалгуур үзүүлэлт”-ийн биелэлтийг 2023 оны III улирлын байдлаар нэгтгэн гаргаж, ЗТХЯ-ны ХШҮДАГ-т 2023.09.15-ны өдрийн албан мэйл хаягаар хүргүүлж тайлагнасан.<br>“Ил тод байдлыг илтгэх 98 шалгуур үзүүлэлт”-ийн биелэлтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж 2023.12.15-ны өдрийн дотор хүргүүлэхээр ажиллаж байна. | |
| | 2.2.2 Үйлдвэрийн газрын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тайлагнасан байдал<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Шалгуур үзүүлэлт**<br>**1-3-р улиралд:**<br>Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ хийгдэж, хамтран ажилласан байна.<br>**4-р улиралд:**<br>Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг тайлагнасан байна. | | ЗСХНХ | 2023 онд байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, цаг үеийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор 2023 онд байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, цаг үеийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор хэвлэл мэдээллийн 15 байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Үүнд:<br>- ETV, Suld TV, Live TV, Парламент Тв<br>- Zogii.mn, Ergelt.mn, Newspress.mn, Tasal.mn, Zarig.mn, Unenmedee.mn<br>- FM 88.3<br>- Монголын мэдээ сонин,<br>- Зууны мэдээ болно.<br>Мөн “Зоргол партнер” ХХК-тай АГГ-23/17 тоот, “Ньюс инфо” ХХК-тай АГГ-23/15 тоот, ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулан хамтран ажиллаж байна.<br>Эдгээр байгууллагуудтай байгуулсан гэрээний хүрээнд цаг агаарын нөхцөл байдал, цахим гэрчилгээ, ачаа тээврийн АН4, дуудлага худалдаа, тээврийн хэрэгслийн хасалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлыг нээлтэй ил тод түгээн нийт гэрээт 4 телевизэд мэдээ өгч, 15 сайтуудаар тухай бүр хэвлэлийн мэдээ бэлтгэн ажилласан байна. Мөн MNB тв, C1, UBS тв, Tv9, Mongol HD телевизэд цаг үеийн мэдээ мэдээллээр ярилцлага өгсөн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Байгууллагын FB пэйж, твиттер, инстаграм хуудсанд өдөр бүр сэрэмжлүүлэг, зорчигч тээвэрлэлтийн мэдээ, дуудлага худалдаа, үнэ тарифын постер бэлтгэн олон нийтэд түгээн ажилласан.<br>Мөн гэрээний хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг улирал бүр тайлагнаж байна.<br>Хамтын ажиллагааны хүрээнд нийт " АТҮТ" ТӨҮГ-ын " Инженер зөвлөж байна" нэртэйгээр 6 цуврал видео, зорчигч тээвэр, ТХБ, Лавлах үйлчилгээ, Мэргэшсэн жолоочийн зэрэг нийт 10 видео бэлтгэн, тээврийн хэрэгслийн шинэчлэсэн бүртгэлдээ хамрагдаарай гэсэн сэдвээр олны танил 10 хүн оролцуулан видео хийлгэн мэдээллийг түгээн ажилласан.<br>ЗТХЯ-наас зохион байгуулсан боловсролын үзэсгэлэнд 1 удаа, Цахим хөгжлийн яамны E- Mongolia 3.0 нээлтэнд 1 удаа оролцож ажилласан.<br>Байгууллагын FB групп шинээр нээн, одоогоор 1300-н гишүүн элсүүлэн, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажиллаж байна.<br>Үйлдвэрийн газрын нэгж бүрийн сошиал хариуцсан ажилтнуудад Brandbook-ийн дагуу мэдээллээ бэлтгэн түгээх сургалтыг явуулж ажиллаж байна.<br>ЗГ-аас зарласан монголд зочлох жилийн хүрээнд АТТ-үүдийн дэлгэцээр холбоотой видео бичлэгүүдийг тогтмол явуулж эхэлсэн.<br>Жуулчин тээвэрлэлт эрхлэж буй иргэд, ААНБ, улс, хот хоорондын зорчигч тээврийн автобусанд тухайн үйл ажиллагаатай холбоотой стикер байрлуулан сурталчлан ажилласан.<br>Хамгийн олон хандалттай Алгаа, Нямка болон MedQ студитэй хамтран Зорчигч тээврийн онлайн тасалбар, Тээврийн хэрэгсэл дээрээ холбогдох дугаараа бичиж тавиарай гэсэн сэдвүүдээр захиалгат контентыг хийлгэн олон нийтэд түгээн ажилласан.<br>Тээврийн хэрэгслийн өмчлөгч та улсын хэмжээнд зохион байгуулж байгаа Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, үзлэг тооллогодоо идэвхитэй хамрагдаж хасалтаа хийлгүүлээрэй. Дэлгэрэнгүй мэдээллийг 24 цагийн лавлах дугаар 1900-1234-өөс сэдвээр 80 удаа цацагдсан.<br>Мөн шинэчилсэн бүртгэлийн тайлангийн шторк видеог хийлгэн олон нийтэд сошиал сувгуудыг ашиглан түгээсэн.<br>Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл тооллогод идэвхтэй хамрагдах уриалга мессежийг 26,270 иргэнд Калл про программ ашиглан илгээсэн.<br>" Үнэн" сонинд байгууллагын үйл ажиллагаа хэтийн төлөвлөгөөний талаар захирал Б. Гүрсоронзон ярилцлага өгсөн.<br>Автотээврийн гэрчилгээ цахим хэлбэрт шилжиж, E-Mongolia-д байршлаа гэсэн мэдээллийг 6 төрлийн постер хийн сошиалаар, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | мөн 5 Телевиз, бүх гэрээт сайтуудаар мэдээ бэлтгэн түгээн ажиллаласан. | |
| | 2.2.3 Өөрсдийн чиг үүргийн хүрээнд цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааныхаа талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тухай бүр сурталчилсан байдал<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Шалгуур үзүүлэлт**<br>**1-4-р улиралд:**<br>Тухай бүр цахимжуулсан үйлчилгээ, үйл ажиллагааныхаа талаар иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан байна. | | ЗСХНХ | Тээрийн хэрэгслийн гэрчилгээг цахимжуулах ажил бэлтгэл ажлын хүрээнд явагдаж байгаатай холбоотойгоор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ерөнхий мэдээлэл түгээж ажиллаж байна.<br>Монгол Улсын Засгийн газраас “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд "Зам, тээврийн хөгжлийн яам", "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ нь автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг цахим хэлбэрт шилжүүлж “E-Mongolia” системд 2023.05.26-ны өдөр албан ёсоор нэвтрүүлээд байна. Цаашид мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг E-Mongolia системд нэвтрэн цахимаар ашиглах боломжтой болсон. Монгол улсад бүртгэлтэй мэргэшсэн жолоочийн бүхий л цахим мэдээллийг байршуулсан болно.<br>Шинээр цахимжуулсан үйлчилгээг тухай бүр олон нийтийн мэдээллийн бүх хэрэгслээр түгээн ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд Autobox гар утасны арр ашиглалтад орох гэж байгаатай холбоотой сурталчилгааны 2 бичлэг хийж түгээхэд бэлэн болгосон.<br>Нийт цахимжсан үйлчилгээний талаар бичлэг бэлтгэн түгээсэн. | |
| Хөрөнгө оруулалт, худалдан авалтын чиглэлээр | | | | | |
| 2.3 | 2.3..1 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулж хэрэгжүүлж ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Төлөвлөгөөт ажлын хэрэгжилт<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-4-р улиралд:** Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна. | - | ЗСХНХ | Тус үйлдвэрийн газрын 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 20 нэр төрлийн 3,318.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн бөгөөд 2023.12.08-ны өдрийн байдлаар дараах үзүүлэлттэй байна.<br>Үүнд: Бүрэн хэрэгжсэн 13 ажил, нийлүүлэлтийн шатандаа явж байгаа 1 ажил, сонгон шалгаруулалтын шатандаа явж байгаа 2 ажил, амжилтгүй болсон 1 ажил, хэмнэсэн 3 ажил байна. | |
| | 2.3..2 Урсгал зардлын төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулж хэрэгжүүлж ажиллах.<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Төлөвлөгөөт ажлын хэрэгжилт<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Шалгуур үзүүлэлт**<br>**1-4-р улиралд:** Урсгал зардлын төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна. | - | ЗСХНХ | Урсгал зардлын шинж чанартай 4 нэр төрлийн 4 багц, 264.2 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2023.12.10-ны өдрийн байдлаар бүрэн хэрэгжсэн 4 ажил байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3. Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.** | | | | | |
| Үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх болон хяналт шалгалт дотоод аудит хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж өгөх, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, удирдлагыг мэдээллээр хангах чиглэлээр | | | | | |
| 3.1 | 3.1.1 Үйлдвэрийн газрын зарим салбар төвүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Аудит хийгдсэн салбар төвийн тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-2-р улиралд:**<br>УБ хотын 2 төвд санхүүгийн аудит хийгдэж, зөвлөмж хүргүүлсэн байна.<br>**3-4-р улиралд:**<br>Орон нутгийн 7 төвд санхүүгийн аудит хийгдэж, зөвлөмж хүргүүлсэн байна. | - | ХШДАА | ХШДАА-ны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу салбар төвүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж зөвлөмж зөвлөгөө өгч ажиллана.<br>Өвөрхангай аймгийн авто тээврийн төвд томилолтоор 2023.05.08,09 нд ажиллаж илэрсэн зөрчил дутагдалд санхүүгийн аудитын чиглэлээр зөвлөмж хүргүүлж зөвлөгөө өгч ажилласан.<br>Өмнөх ажлаас өгөгдсөн зөвлөмжийн дагуу шөнийн ээлжээр ажиллах хуваарийг гарган баталгаажуулж, ажилтан бүрт танилцуулж хэвшсэн байна.<br>Үндэсний аудитын газраас 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийн биелэлтэнд хяналт тавьж танилцан хүсэлтийг илгээсэн бөгөөд холбогдох газруудаас тайлбар авч ажилласан.Хөвсгөл Булган Орхон аймгийн төвүүдэд санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдэж, зөвлөмж хүргүүлэн ажилласан. | |
| | 3.1.2 Байгууллагын дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт 50-аас доошгүй хувь биелсэн байна.<br>**2-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилт 70-аас доошгүй хувь биелсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилт 80-аас доошгүй хувь биелсэн байна.<br>**4-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажил 90-ээс дээш хувь биелсэн байна | - | ХШДАА | 2023.01.10-ны өдөр тус үйлдвэрийн газрын дотоод хяналт, шалгалтын 2023 оны төлөвлөгөөг үйлдвэрийн газрын захирлаар батлуулан ажиллаж байна. Мөн орон нутгийн салбар төвүүдийн 2023 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг төвийн дарга нараар батлуулан 1 дүгээр улирлын биелэлт нэгтгэн авахаар ажиллаж байна.<br>Батлагдсан төлөвлөгөөний хүрээнд 2023.01.26-27-ны өдрүүдэд Улаанбаатар хот дахь Баянгол, Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төвүүдэд, 2023.02.17-нд Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд, дэнжийн 1000 техникийн хяналтын үзлэгийн төвд, 2023.03.03-ны өдрүүдэд Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төв, зорчигч тээврийн төв, “Да хүрээ зах” дахь тээврийн хэрэгслийн бүртгэл,техникийн хяналтын үзлэгийн төвүүдэд зохих журам төлөвлөгөөний хүрээнд хяналт шалгалтыг тогтмол тавьж байна.<br>2023.03.16-ны байдлаар ААНэгж байгууллага, иргэдээс ирүүлсэн 4 санал хүсэлт, өргөдөл гомдлын дагуу хяналт шалгалт хийж хуулийн хугацаанд хариуг хүргүүлэн, “Хөдөлмөрийн дотоод журам” зөрчсөн, албан тушаал /ажлын байр/-ны тодорхойлолтын холбогдох заалтуудыг биелүүлээгүй 6 албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах тухай санал дүгнэлтийг ЗСХНХ-т хүргүүлэн ажилласан.<br>2023.04.20-нд СХТХҮТ, Стандарт, хэмжил зүйн газар, Драгон СХЗТТ-д, 2023.05.08-нд Баянзүрх техиник хяналт оношлогооны төв болон Баянзүрх зорчигч тээврийн төвд, 08-р сарын 15 нд БЗЗТТ, БЗТХҮТ “Таван Ган Трейд” ХХК, Да Хүрээ, СХЧУТ, СХТХҮТ зэрэг | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | салбаруудад цаг ашиглалт болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны талаар дотоод хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчилд зөвлөгөө өгч ажилласан болно. | |
| | 3.1.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг тогтоосон хугацаанд үнэн, зөв мэдээллэсэн эсэхэд байнгын хяналт тавьж, шилэн дансны цахим хуудасны нэгдсэн тайланг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор холбогдох газарт хүргүүлж, тайлагнах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт 50-аас доошгүй хувь биелсэн байна.<br>**2-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилт 70-аас доошгүй хувь биелсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилт 80-аас доошгүй хувь биелсэн байна.<br>**4-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажил 90-ээс дээш хувь биелсэн байна. | - | ХШДАА | 2023 оны 3 дугаар улирлын байдлаар тус үйлдвэрийн газрын хэмжээнд нийт мэдээллэх 3317 мэдээлэл байна. Үүнээс:<br>✓ Хугацаандаа мэдээлсэн - 3287<br>✓ Хугацаа хоцроож мэдээлсэн – 30<br>Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулж байгаа эрх бүхий албан тушаалтнуудад мэдээллийн агуулгыг үнэн зөв мэдээлэх тал дээр тухай бүр нь заавар, зөвлөгөө өгч мэдээллээр ханган ажиллаж байна. Мөн сахилга, хариуцлагыг сайжруулж, хуулийн хугацаанд мэдээллээ оруулж байх талаар дотоод сүлжээгээр мэдээлэл байршуулан тухай бүрт нь анхааруулга зөвлөмж өгч ажиллаж байна. 2023 оны 1-р улирлын шилэн дансны тайлан мэдээг 2023.04.07-ны өдрийн 1/464 тоот албан бичгээр, 2023 оны 2-р улирлын шилэн дансны тайлан мэдээг 2023.07.07-ны өдрийн 1/964 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. 2023 оны 3-р улирлын шилэн дансны тайлан мэдээг 2023.10.06-ны өдрийн 1/1282 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. 2023 оны 4-р улирлын шилэн дансны тайлан мэдээг хуулийн хугацаанд буюу 2024.01.08-ны дотор ЗТХЯ болон Сангийн яаманд хүргүүлнэ. | |
| | 3.1.4 “Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу холбогдох хэлтсээс хариуг авч нэгтгэн, танилцуулж, Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Өргөдөл гомдлын шийдвэрлэлт<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>1-4-р улиралд:<br>Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна. | | ХШДАА | Тус үйлдвэрийн газрын үндсэн чиг үүрэгтэй хамааралгүй санал хүсэлт, гомдол 46 буюу нийт санал хүсэлт, гомдлын 17 хувийг эзэлж байх тул хариуг шийдвэрлэх байгууллагад нь шилжүүлж өгөхийг “Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв”-д 2023.06.13-ны өдрийн 1/790 тоот албан бичгээр уламжилсан болно.<br>Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт тус үйлдвэрийн газрын 2023.07.25-ны өдрийн 1/1014 тоот албан бичгээр гомдол, санал хүсэлтийг хариуцаж хариу өгч шийдвэрлэж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийсэн дүнг хүргүүлсэн.<br>“Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв”-д 2023.12.08-ны өдрийн байдлаар оны эхнээс өссөн дүнгээр тус үйлдвэрийн газрын нэр дээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт санал хүсэлт-62, гомдол-390, Шүүмжлэл-3, талархал-3 ирсэн байна. Үүнээс: Санал хүсэлт-62, гомдол-389, Шүүмжлэл-3, талархал-3 хариуг өгч шийдвэрлэсэн. Хяналтад 1 гомдол байна. | |
| | 3.1.5 Үйлдвэрийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулах<br>**Шалгуур үзүүлэлт** | | ХШДАА | Үйлдвэрийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд нэгдүгээр улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт-95 хэрэгжүүлэх арга хэмжээнээс “Бүрэн хэрэгжсэн”-41, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Хяналт шинжилгээ үнэлгээний дүн<br>**Хугацаа**<br>II,IV-р улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-4-р улиралд:**<br>Үйлдвэрийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хагас, бүтэн жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулсан байна. | | | “Хэрэгжих шатанд”-36, “Хэрэгжилт хангалтгүй”-5, “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-13, биелэлт /хувиар/ 82,6 хувьтай бөгөөд 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр захиралд танилцуулсан.<br>- Зам, тээврийн хөгжлийн яамны шалгалтын ажлын хэсэг шаардсаны дагуу албаны даргад танилцуулан dbyambadulam@mrtd.gov.mn цахим хаягаар 2023.06.21-ний өдөр хүргүүлэв.<br>Үйлдвэрийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт-95 хэрэгжүүлэх арга хэмжээнээс “Бүрэн хэрэгжсэн”-53, “Хэрэгжих шатанд”-39, “Хэрэгжилт хангалтгүй”-1, биелэлт /хувиар/ 87,6 хувьтай бөгөөд 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр захиралд танилцуулсан.<br>Үйлдвэрийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд гуравдугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт-95 хэрэгжүүлэх арга хэмжээнээс “Бүрэн хэрэгжсэн”-73, “Хэрэгжих шатанд”-21, “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-1, биелэлт /хувиар/ 93,2 хувьтай бөгөөд үйлдвэрийн газрын захиралд танилцуулсан. | |
| | 3.1.6 Үйлдвэрийн газрын Хэлтсүүд, Улаанбаатар болон орон нутгийн төв салбарын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Хяналт шинжилгээ, үнэлгээний дүн<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-4-р улиралд:**<br>Үйлдвэрийн газрын Хэлтсүүд, Улаанбаатар болон орон нутгийн төв салбарын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд улирал бүр ХШҮ хийж, удирдлагад танилцуулсан байна. | | ХШДАА | Үйлдвэрийн газрын 2023.01.03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 2.8-д “Үйлдвэрийн газрын нэгж, салбарууд тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг жилийн эхнээс өссөн дүнгээр гаргаж, улирлаар тухай улирлын сүүлийн сарын 25-ны дотор, хагас жилээр 6 дугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон 25-ны дотор, бүтэн жилийн тайланг хүлээгдэж буй гүйцэтгэлээр /12 дугаар сарын 31-нээр тасалбар болгож/ 12 дугаар сарын 15-ны дотор тус тус бичмэл тайлангийн хамт Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгжид ирүүлнэ.” гэж заасны дагуу биелэлтэд нэгжүүдийн 2023 оны 1 дүгээр улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад танилцуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн, зөвлөмжийг дотоод сүлжээний захидлаар нэгжийн удирдлагуудад хүргүүлсэн болно.<br>Эхний хагас жилээр 6 дугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон 25-ны дотор нэгжүүд биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад танилцуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн, зөвлөмжийг дотоод сүлжээний захидлаар нэгжийн удирдлагуудад хүргүүлсэн болно.<br>3 дугаар улирлын нэгжүүдийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад танилцуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн, зөвлөмжийг дотоод сүлжээний захидлаар нэгжийн удирдлагуудад хүргүүлсэн болно. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 4: Хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг сайжруулан, ажилтан ажиллагсдын сургалтын хэрэгцээг нарийвчлан тодорхойлж, ур чадвар олгоход чиглэгдсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сургалтын агуулга, чанар, үр өгөөжийг дээшлүүлнэ.** | | | | | |
| Мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэн ажиллах ба ажилтнуудыг хөгжүүлэх, чадавхжуулах талаар холбогдох сургалтыг байгууллагынхаа хэмжээнд тогтмол зохион байгуулах, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажиллах чиглэлээр | | | | | |
| 4.1 | 4.1.1 Ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх 2023 оны сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Сэтгэл ханамжийн судалгааны дүн<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Төлөвлөгөө боловсруулж, батлуулж, төлөвлөгөөнд тусгагдсан 5 сургалт зохион байгуулагдсан байна.<br>**2-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан 10 сургалт зохион байгуулагдаж, ажилтнуудаас сургалтын талаар авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн 5-аас дээш үнэлэгдсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан 15 сургалт зохион байгуулагдсан байна.<br>**4-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан 20 сургалт зохион байгуулагдаж, Ажилтнуудаас сургалтын чанар, үр дүнд өгсөн сэтгэл ханамжийн судалгаа 6-аас дээш үнэлэгдсэн байна | - | ЗСХНХ СХЧУТ | Үйлдвэрийн газрын “Ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх 2023 оны сургалтын төлөвлөгөөг батлан, төлөвлөгөөнд тусгасан 2 сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт 182 ажилтан албан хаагчийг хамруулан сургасан. Үүнд:<br>-Монголын Автоинженерүүдийн холбоотой хамтран “Техникийн хяналтын үзлэгийн инженер, техникч нарыг мэргэшүүлэх” 16 цагийн сургалтыг зохион байгуулж аймгийн автотээврийн төвийн нийт 49 техникийн хяналтын үзлэгийн инженер, техникчийг;<br>-ШУТИС-ийн МИС-тай хамтран “Тээвэр зохион байгуулагчийн мэргэшүүлэх” 24 цагийн сургалтыг зохион байгуулж, үйлдвэрийн газрын нийт 133 тээвэр зохицуулагчийг мэргэшүүлэх сургалтад тус тус хамруулан сертификат олгосон.<br>-Гүйцэтгэлийн удирдлагын систем сэдвээр Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх талаар Хяналт, шинжилгээ дотоод аудитын албаны 2 мэргэжилтэн хамрагдсан.<br>-Callpro компанитай хамтран Харилцааны ёс зүйн, Үйлчилгээний чадавхи, лавлах утасны оператор ажилтны сэтгэл зүйн бэлтгэл чиглэлээр Лавлах үйлчилгээний тасгийн 18 мэргэжилтэнг хамруулсан.<br>-Иргэдэд үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудад харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр Хууль сахиулахын их сургуулийн багш нартай хамтран “Байгууллагын соёл ба харилцаа“, “Албан хаагчийн хүлээх үүрэг, хариуцлага” сэдэвт сургалт зохион байгуулж, үйлдвэрийн газрын нийт 163 ажилтанг хамруулсан.<br>-Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран үйлдвэрийн газрын нийт нягтлан бодогч нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулсан.<br>-Нийслэлийн Прокурорын газартай хамтран “Хяналтын чиг үүрэг хэрэгжүүлж буй эрх бүхий албан тушаалтнууд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл журмын дагуу явуулсан эсэх, шийтгэл ногдуулсан шийдвэр хууль зүйн үндэслэлтэй эсэх” сэдвээр танхимын болон цахим сургалт зохион байгуулж, 57 автотээврийн хяналтын мэргэжилтэнг хамруулан, заавар зөвлөмж өгсөн.<br>-Стандарт хэмжил зүйн газраас зохион байгуулсан “Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох” сургалтад Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төвийн 4 албан хаагч хамрагдсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | -ХАБЭА-н нийт ажилтны сургалтыг зохион байгуулж, 363 ажилтан хамрагдсан.<br>-Үйлдвэрийн газрын нийт 33 нягтлан бодогч шилэн дансны системийн талаарх сургалтад онлайнаар хамрагдсан.<br>- Хөдөлгөөний удирдлагын хэлтсийн 4 мэргэжилтэн Amazon Web Service, Flutter 3.0, Graphql өгөгдлийн сан зэрэг сургалтуудад онлайнаар хамрагдсан.<br>- Стандарт хэмжилзүйн газраас зохион байгуулдаг дараах сургалтуудад хамрагдсан. Үүнд:<br>✓ Баталгаажуулалтын шинжээчийн эрх олгох сургалтад 1 ажилтан хамрагдсан.<br>✓ MNS ISO 190011: 2016 Менежментийн тогтолцоонд аудит явуулах арга зүй сургалтад 2 ажилтан хамрагдсан.<br>✓ MNS ISO 31000 : 2020 Эрсдэлийн менежмент Удирдамж сургалтад 4 ажилтан хамрагдсан.<br>- ШУТИС – МИС-аас зохион байгуулсан “Тээвэр зохицуулагчийн сургалтад” 1 ажилтан хамрагдсан.<br>Зах зээлийн судлалын хүрээлэнгээс “Төслийн ТЭЗҮ боловсруулах арга зүй” сэдэвт сургалтад 4 ажилтан хамрагдсан. | |
| | 4.1.2 Авлигыг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн сургалтыг үе шаттай зохион байгуулах.<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Сургалтын тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улирал:**<br>Үйлдвэрийн газрын 2023 оны сургалтын төлөвлөгөөнд тусган батлуулсан байна.<br>**2-4-р улирал**<br>2-оос доошгүй сургалт зохион байгуулсан байна. | - | ЗСХНХ | Үйлдвэрийн газрын сургалтын төлөвлөгөөний дагуу авлигыг үл тэвчих хандлагыг бий болгоход чиглэсэн төлөвлөгөөт сургалтуудыг зохион байгуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд удирдах ажилтны зөвлөгөөний үеэр удирдах албан тушаалтнуудад “Авлигатай тэмцэх газрын танилцуулга, авлигаас урьдчилан сэргийлэх арга технологи” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.<br>- 2023.06.29-ний өдөр Дотоод хэргийн их сургуулийн доктор, дэд профессор Н.Мөнхзул “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Эрүүгийн хууль”, “Авлигын эсрэг хууль”, “Төрийн албаны тухай хууль”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм” -үүдээс “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ”-н чиглэлээр сургалт хийж, үйлдвэрийн газрын аймгийн Автотээврийн төв, салбар, УБ хот дахь төв, хэлтсийн давхардсан тоогоор нийт 340 гаруй албан хаагчийг цахим сургалтад хамруулсан.<br>- 2023.02.09-10-ны болон 2023.10.02-ны өдрүүдэд Авлигатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран авлигын эрсдэлийн талаар, авлигын эсрэг хуулийн талаар болон авлигыг үл тэвчих хандлагын талаарх сургалтыг үйлдвэрийн газрын орон нутгийн 23 салбарын дарга, нийслэлийн нийт 18 нэгжийн дарга нарт мөн тус үйлдвэрийн газрын нийт инженер, техникийн ажилтнууд, мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 4.1.3 Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>1-р улиралд:<br>Төлөвлөгөө боловсруулж, батлүүлсан байна.<br>2-4-р улиралд:<br>Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна. | 200 сая,төг | ЗСХНХ | Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөөний дагуу үйлдвэрийн газрын ажилтны нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам"-д нийцүүлэн байр, орон сууц худалдан авах, байр, орон сууцны нөхцөлөө сайжруулах, эрүүл мэндээ хамгаалах, сургалтын зардалд нь дэмжлэг үзүүлэхийг хүссэн ажилтнуудын өргөдөл хүсэлтийг судлан шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг захирлын 2023.03.21-ний өдрийн А/69 дүгээр тушаалаар баталсан. Тус ажлын хэсэг дэмжлэг хүссэн нийт ажилтнуудын өргөдөл хүсэлтийг хүлээн авч, судлан, шийдвэрлэх саналыг Захирлын зөвлөлийн 2023.05.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2023.05.31-ний өдрийн А/127 дугаар тушаалаар 40 ажилтанд тус бүрд 5,0 сая төгрөг буюу нийт 200,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | |
| **Зорилт 5: Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай, хүртээмжтэй тээврийн үйлчилгээг зохион байгуулна.** | | | | | |
| Ачаа болон зорчигч тээвэрлэлтийг үйлчилгээний тоог нэмэгдүүлэх чиглэлээр | | | | | |
| 5.1 | 5.1.1 Улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчийг сонгон гэрээ байгуулан батлагдсан тээвэрлэлтийн чиглэл, үйлчилгээний давтамж, цагийн хуваарийн дагуу үйлчилгээг зохион байгуулах;<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тээвэрлэсэн зорчигчийн тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-3-р улиралд:**<br>Батлагдсан тээвэрлэлтийн чиглэл, үйлчилгээний давтамж, цагийн хуваарийн дагуу үйлчилгээг зохион байгуулсан байна.<br>**4-р улиралд:**<br>Улс хот хооронд 1,4 сая зорчигч тээвэрлэсэн байна | - | ЗТХ | Хот хоорондын тээвэрлэлт: Өссөн дүнгээр 2023.12.10-ны өдрийн байдлаар 49 чиглэлд 35125 т.х 1,295,000 зорчигч тээвэрлэсэн. Өмнөх онтой харьцуулахад 0,4%-иар өссөн байна.<br>Улс хоорондын чиглэлд 3 улсын 13 чиглэлд 18 ААНБ-ын 128 тээврийн хэрэгсэл 247 мэргэшсэн жолоочтойгоор /давхардсан тоогоор/ тээвэрлэлтийг гүйцэтгэж байна. 2023.12.10-ны байдлаар нийт 825,851 мянган зорчигч тээвэрлэсэн байна.<br>Улс, хот хооронд 2023.12.10-ны өдрийн байдлаар 2,120,851 зорчигч тээвэрлэсэн бөгөөд төлөвлөлтийг 160%-иар давуулан биелүүлсэн. | |
| | 5.1.2. Хот хоорондын нийтийн тээврийн замналын паспорт хөтлөх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Замналын паспортын баяжуулалтын тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-4-р улиралд:**<br>Үлдсэн 5 чиглэлийн замналын паспортод баяжуулалт хийгдсэн байна | 10 сая.төг | ЗТХ | Хот хоорондын нийтийн тээврийн үлдсэн 5 чиглэлийн замналын паспортыг хөтлөх ажлыг 2023.11.15 – 2023.11.25-ны өдрийг дуустал хугацаанд тухайн чиглэлийн байршил тогтоох төхөөрөмжтэй тээврийн хэрэгслүүдийн хар хайрцагт тулгуурлан хийж дуусган 5 чиглэлийн замналын паспортод баяжуулалт хийсэн. | |
| | 5.1.3 Зорчигч тээвэрлэх дүрмийн шинэчилсэн төслийг боловсруулж, яаманд хүргүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Төсөл боловсруулж, яаманд хүргүүлсэн байдал<br>**Хугацаа**<br>I-III улирал | 3 сая.төг | ЗТХ | Автотээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэх дүрмийн төсөлд өөрчлөлт оруулах саналыг боловсруулан 2023.10.10-ны өдрийн 1/1296 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Шинэчилсэн төслийг боловсруулсан байна.<br>**2-р улиралд:**<br>Шинэчилсэн төслийг хэлэлцүүлсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Саналуудыг нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлсэн байна. | | | | |
| | 5.1.4 Боомтуудын ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Шивээ хүрэн боомтод автомат удирдлагатай тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Шивээ хүрэн боомтоор нэвтэрсэн ачааны тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Туршилтын тээврийг хийсэн байна.<br>**2-р улиралд:**<br>Шивээ хүрэн боомтоор тээвэрлэлтийг эхлүүлсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Нүүрсний экспорт нэмэгдсэн байна.<br>**4-р улиралд:**<br>Нэгдсэн зохион байгуулалтад орсон байна | - | АТХ | Хилийн дундын бүсэд AGV /Automatic Gueded Vehicle/ буюу автомат удирдлагатай тээврийн хэрэгслээр нүүрс тээвэрлэлтийг 2022.12.27-ны өдөр эхлүүлсэн.<br>Шивээхүрэн боомтоор 2023.12.10-ны өдрийн байдлаар 145,705 тээврийн хэрэгслээр 17,256,491 тонн нүүрс тээвэрлэснээс AGV /Automatic Gueded Vehicle/ буюу автомат удирдлагатай 8,734 тээврийн хэрэгслээр 570,010 тонн нүүрс тээвэрлэж өмнөх оны мөн үеийнхээс 221%-иар өсөж нэгдсэн зохион байгуулалтад оруулан ажилласан. | |
| Жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг зохион байгуулах, бүртгэл хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр | | | | | |
| **5.2** | 5.2.1. Жуулчин тээврийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-аар дамжуулан зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>www.e-mongolia.mn –д бүртгэлтэй жуулчин тээвэрлэгчийн тоо<br>**хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд**<br>Жуулчин тээврийн ААНБ-уудад жуулчин тээврийн үйлчилгээг e-mongolia системд нэвтэрсэн талаарх танилцуулга мэдээллийг өгсөн байна.<br>**2-4-р улиралд:**<br>Төрийн үйлчилгээний нэгдсэн порталд /www.e-mongolia.mn/ жуулчин тээврийн үйлчилгээг зохион байгуулж жуулчин таних тэмдгийг олгосон байна. | - | **ЗТХ** | Жуулчин тээврийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /www.e-mongolia.mn/-аар дамжуулан зохион байгуулахад төрийн үйлчилгээний хур системд гацалт үүсч E-mongolia дээр хөгжүүлэлт хийх боломжгүй талаар мэдэгдсэн тул Жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг Тээврийн нэгдсэн системийн программаар дамжуулан зохион байгуулахаар болж бүрэн дууссан бөгөөд 2024 оноос эхлэн ашиглахаар бэлтгэл ажлыг хангасан.<br>Монгол улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан жуулчин тээврийн үйлчилгээ эрхлэгч хувь жолооч нартай гэрээ байгуулан ажиллаж байна. 2023.12.10-ны байдлаар 89 аж ахуйн нэгж байгууллага, 175 хувь жолооч нартай гэрээ байгуулан 827 “Жуулчин” таних тэмдэг олгосон. | |
| | 5.2.2 Хавирга-Ар хашаатын боомтыг түшиглэн зорчигчдын тогтмол бус тээврийн /жуулчин/ чиглэлийн үйлчилгээг эхлүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Жуулчдын тоо | - | **ЗТХ** | Дорнод аймгийн төв Чойбалсан сумаас Хавирга-Ар хашаатын боомтоор ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Шинэ барга баруун хошууны “Алтан эмээл балгас” хүртэл зорчигчдын тогтмол бус тээврийн үйлчилгээг эхлүүлсэн бөгөөд зорчигчдын тогтмол бус | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-2-р улиралд:**<br>Бэлтгэл ажлуудыг хангасан байна.<br>**3-4-р улиралд:**<br>Зорчигчдын тогтмол бус тээврийн /жуулчин/ үйлчилгээг эхлүүлсэн байна | | | тээврийн чиглэлд олгодог В төрлийн зөвшөөрлийн бичгийг Тээврийн нэгдсэн системд холбон цахимаар олгон ажиллаж байна. 2023.12.10-ны өдрийн байдлаар 1,464 ширхэг В төрлийн бичиг олгосон байна. | |
| Иргэдэд тээврийн үйлчилгээг ойртуулах зорилгоор тээшний хэмжээг тогтоох жин хэмжүүр, тээш хадгалах зориулалтын байрыг бий болгох, тээшний тасалбар олгох чиглэлээр | | | | | |
| **5.3** | 5.3.1 Илгээмжийн ачааг хүлээн авах, бүртгэлжүүлэх, хадгалах, тээвэрлэх, хүлээлгэн өгөх үйлчилгээг автобуудалтай аймгуудад зохион байгуулах;<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Зорчигчийн тээш хүлээн авах цэгүүдийн тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-4-р улиралд:**<br>Орон нутгийн салбаруудад илгээмжийн ачааг бүртгэлжүүлж, хүлээлгэн өгөх үйлчилгээг автобуудалтай аймгуудад өргөжүүлэн зохион байгуулсан байна. | - | АТХ | Авто буудлын стандартын шаардлага хангасан Улаанбаатар хотын 2 салбар, орон нутгийн 8 салбараар дамжуулан 2023 онд илгээмжийн ачааг хүлээн авах, бүртгэлжүүлэх, түр хадгалах, тээвэрлэх, хүлээлгэн өгөх үйлчилгээг зохион байгуулан ажилласан. Мөн 2023 оны сүүлийн эцэст авто буудалтай аймгуудад болох Хэнтий, Баян-Өлгий, Дорноговь, Дорнод, Сүхбаатар аймгуудад илгээмжийн үйлчилгээг өргөжүүлэн нийт 5 аймагт зохион байгуулан ажиллаж байна. | |
| **Зорилт 6: Улс хоорондын тээвэрлэлтийн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.** | | | | | |
| Уулзалт, хурал, зөвлөгөөний бэлтгэл ажлыг хանган, шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр | | | | | |
| 6.1 | 6.1.1 Монгол Улс болон БНХАУ-ын ӨМӨЗО, ШУӨЗО-ны Автотээврийн төлөөлөгчдийн 2023 оны ээлжит уулзалтуудыг тус тус зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Уулзалтууд зохион байгуулагдсан байдал<br>**Хугацаа**<br>IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**4-р улиралд:**<br>БНХАУ-ын 2023 оны ээлжит уулзалтууд зохион байгуулагдсан байна. | 35.0 сая.төг | АТХ | БНХАУ-ын ШУӨЗО, ӨМӨЗО-той хийх Автотээврийн төлөөлөгчдийн 2023 оны ээлжит уулзалтаар хэлэлцэх асуудлын саналыг хилийн боомттой аймгуудаас нэгтгэн ЗТХЯ-нд 2023.06.14-ны өдрийн 1/796 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>БНХАУ-ын ШУӨЗО-той хийх Автотээврийн төлөөлөгчдийн 2023 оны ээлжит уулзалтыг 2023.09.11-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулсан.<br>Мөн БНХАУ-ын ӨМӨЗО-той хийх Автотээврийн төлөөлөгчдийн 2023 оны ээлжит уулзалтыг 2023 оны 12 дугаар сарын 17-24-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаn ажиллаж байна. | |
| | 6.1.2 Монгол Улс болон БНХАУ-ын ӨМӨЗО, ШУӨЗО-ны Автотээврийн төлөөлөгчдийн 2024 онд ашиглах зөвшөөрлийн бичиг солилцох уулзалтуудыг тус тус зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Зөвшөөрлийн бичиг солилцсон байдал<br>**Хугацаа**<br>IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**4-р улиралд:** | 15.0 сая.төг | АТХ | БНХАУ-ын ШУӨЗО-той хийх Автотээврийн төлөөлөгчдийн 2023 оны ээлжит уулзалтыг 2023.09.11-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулсан бөгөөд хил нэвтрэх зориулалттай зорчих болон онцгой төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг 2023 оны 12 дугаар сарын эхний 10 хоногт ШУӨЗО-ны Такашикен тосгонд солилцохоор тохиролцсон.<br>12.01-ны өдрийн М007 тоот албан бичгээр 2024 онд ашиглагдах зөвшөөрлийн бичгийг ШУӨЗО-ны Такашикен тосгонд 12.14-ний өдөр солилцохоор албан бичиг ирсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | БНХАУ-ын 2024 онд ашиглагдах зөвшөөрлийн бичгийг хэвлүүлж, солилцсон байна. | | | | |
| | 6.1.3 Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах Хамтарсан хорооны гуравдугаар хуралд оролцож, хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хангах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Шийдвэрийн хэрэгжилт<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>1-р улиралд: Хурлын бэлтгэл ажлыг хангах шинжээчдийн уулзалтыг хийнэ.<br>2-р улиралд: Хурлын бэлтгэл ажлыг хангана.<br>3-р улиралд: Хурал зохион байгуулна.<br>4-р улиралд: Хурлын шийдвэр хэрэгжсэн байна | 30 сая.төг | АТХ | Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Хамтарсан хорооны гуравдугаар хурал 2023.09.06-ны өдөр цахимаар зохион байгуулагдаж, тус үйлдвэрийн газрын Ачаа тээврийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Дамдинпүрэв, мэргэжилтэн Э.Ганзориг нар оролцсон. Засгийн газар хоорондын хэлэлцээр хамтарсан хорооны гуравдугаар хурлын шийдвэрийн дагуу АН-4 транзит туршилтын тээвэрлэлтийг 2023.09.22-ны өдөр БНХАУ-ын ШУӨЗО-ны Үрэмч хотоос албан ёсоор эхлүүлж, 2023.09.23-ны өдөр Ховд аймгийн Булган боомтоор Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирсэн. Ховд, Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрээр дамжин Цагааннуур боомтоор 2023.09.25-ны өдөр гарч ОХУ-ын Новосибирск хот хүртэл туршилтын тээвэрлэлтийг амжилттай зохион байгуулж засгийн газар хоорондын хэлэлцээр мөн хамтарсан хорооны хурлын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан. | |
| | 6.1.4 Азийн авто замаар олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд АН-4 чиглэлээр туршилтын тээвэрлэлт зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тээвэрлэлт эхэлсэн байдал<br>**Хугацаа**<br>I-III улирал<br>**Зорилтот түвшин**<br>1-р улиралд: Туршилтын тээвэрлэлтийг явуулах саналыг орос, хятадын талд хүргүүлнэ.<br>2-р улиралд: Туршилтын тээвэрлэлт явуулах бэлтгэл ажлыг хангах шинжээчдийн уулзалтыг зохион байгуулна.<br>3-р улиралд: Туршилтын тээвэрлэлтийг зохион байгуулна. | 30 сая.төг | АТХ | Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын гурван талт хэлэлцээрийн дагуу АН-4 транзит туршилтын тээвэрлэлтийг 2023.09.22-ны өдөр БНХАУ-ын ШУӨЗО-ны Үрэмч хотоос албан ёсоор эхлүүлж, 2023.09.23-ны өдөр Ховд аймгийн Булган боомтоор Монгол улсын нутаг дэвсгэрт орж ирсэн. Ховд, Баян-Өлгий аймгийн нутаг дэвсгэрээр дамжин Цагааннуур боомтоор 2023.09.25-ны өдөр гарч ОХУ-ын Новосибирск хот хүртэл туршилтын тээвэрлэлтийг амжилттай зохион байгуулсан. | |
| | 6.1.5 Автомат удирдлагатай тээврийн хэрэгслийг бүртгэн улс хоорондын зөвшөөрлийн бичиг олгож, хил хооронд байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тээвэрлэлт эхэлсэн байдал<br>**Хугацаа**<br>I-II улирал<br>**Зорилтот түвшин**<br>1-р улиралд: Автомат удирдлагатай тээврийн хэрэгслийг бүртгэж, улсын дугаар олгож, холбогдох зөвшөөрлийн бичгийг олгох | - | АТХ | Автомат удирдлагатай Монгол улсад бүртгэлтэй “Смарт эко транс” ХХК-ийн 6 тээврийн хэрэгсэлд хил нэвтрэх зориулалттай “С” төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг 2023.03.17-ны өдөр олгож, тээвэрлэлт эхлэх нөхцөлийг бүрдүүлсэн. “Смарт эко транс” ХХК автомат удирдлагатай 6 тээврийн хэрэгсэл нэмж оруулж ирсэн ба тус үйлдвэрийн газраас 2023 оны 2 дугаар улиралд 12 зөвшөөрлийн бичиг олгосон. “Смарт эко транс” ХХК нийт 30 автомат удирдлагатай тээврийн хэрэгсэл оруулахаар төлөвлөсөн ба төлөвлөгөөний дагуу 2023 оны 03 дугаар сард, 6, 06 дугаар сард 6, 08 дугаар сард 18 тус тус оруулж ирсэн. Тус үйлдвэрийн газраас зөвшөөрлийн бичгийг түргэн шуурхай олгож, автомат удирдлагатай | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 2-р улиралд: Тээвэрлэлт эхэлсэн байна. | | | тээврийн хэрэгслийг тээвэрлэлтэд оролцуулж ажилласан ба 2023 оны 3 дугаар улиралд нийт 30 тээврийн хэрэгсэлд зөвшөөрлийн бичиг олгон тээвэрлэлтэд оролцуулсан. | |
| | 6.1.6 БНХАУ-тай хиллэдэг авто замын боомтоор зорчигчийн хөдөлгөөн нээгдсэн үед улс хоорондын зорчигчийн тогтмол тээврийг эхлүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тээвэрлэлт эхэлсэн байдал<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>1-4-р улиралд: Тээвэрлэлт эхэлсэн байна. | - | ЗТХ | БНХАУ-тай хиллэдэг хилийн боомтуудын зорчигчийн тогтмол тээвэрлэлтүүдийг 2023 оны 01 дүгээр сарын 08-ний өдрөөс үе шаттайгаар нээн “Улаанбаатар хот – БНХАУ.Эрээн”, “Дг.Замын-Үүд – БНХАУ.Эрээн”, “Дг.Замын-Үүд – БНХАУ.Хөх хот”, “До.Хэрлэн – БНХАУ.Манжуур хот”, “Хо.Булган – ШУӨЗО.Такешикен” болон зорчигчийн тогтмол бус тээвэрлэлтийн маршрут болох “Өмнөговь аймгийн Гурвантэс сум - Шивээхүрэн боомт – БНХАУ.Сэхээ боомт – ӨМӨЗО.Альшаа аймгийн Эзний хошууний Далайн хөв балгас” чиглэлд зорчигч тээврийн үйлчилгээг эхлүүлээд байна. | |
| | 6.1.7 Автотээврийн харилцааг өргөжүүлэх чиглэлээр яамнаас зохион байгуулах уулзалтад оролцох шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Дэмжлэг үзүүлсэн байдал<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>1-4-р улиралд: ЗТХЯ-наас зохион байгуулах уулзалтуудад оролцож, шаардлагатай дэмжлэг үзүүлсэн байна | 40 сая.төг | АТХ | Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотноо 2023.05.23-27-ны өдрүүдэд “Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг тохиролцох үүрэг бүхий ажлын хэсэг 2023.05.25-26-ны өдрүүдэд хэлэлцээрийн шинэчилсэн төслийг эрчимтэй хэлэлцүүлсний үр дүнд хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцсон. Уг төсөлд тус үйлдвэрийн газрын АТХ-ийн дарга О.Энхбат, АТХ-ийн мэргэжилтэн Г.Мөнхтулга нар оролцож шаардлагатай шаардалгатай дэмжлэг үзүүлж ажилласан.<br>Мөн ЗТХЯ-наас 2023 оны 11 дүгээр сарын 6-наас 10-ны өдрүүдэд зохион байгуулсан “Бүсийн тээвэр, логистикийн холболтыг бэхжүүлэх нь сэдэвт” “Тээврийн долоо хоног” олон улсын форумд оролцож шаардлагатай дэмжлэг үзүүлж ажилласан. | |
| | 6.1.8 Олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах үүрэг бүхий Үндэсний тээврийн хорооны хурлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх<br><br>**Шалгуур үзүүлэлт**<br>Дэмжлэг үзүүлсэн байдал<br>**Хугацаа**<br>II, IV улиралд<br>**Зорилтот түвшин**<br>2-р улиралд: Хорооны хурал зохион байгуулагдсан байна.<br>4-р улиралд: Хорооны хурал зохион байгуулагдсан байна | 10.0 сая төг | АТХ | Үндэсний тээврийн хорооноос хурал зарлагдаагүй байна. | |
| | 6.1.9 “Олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн багийн ажлын тухай Европын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор тээврийн хэрэгслийн хяналтын төхөөрөмжийн баталгаажуулалт хийх ажлын бэлтгэлийг хангах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Шийдвэр гаргуулсан байдал | - | СХЧУТ | Бэлтгэл ажил хангах хүрээнд эрх бүхий тахографын төвд тавигдах шаардлагыг тодорхойлох судалгааны ажил хийгдсэн. Тус судалгаагаар Их Британи, Австрали, Америк улсын холбогдох эрх бүхий байгууллагаас дээрх хүрээнд тахографын төвд тавьдаг шаардлагуудыг судалж заавал дагаж мөрдвөл зохих шаардлагуудыг нэгтгэн гаргасан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Хугацаа**<br>I- IV улиралд<br>**Зорилтот түвшин**<br>2-р улиралд: Баталгаажуулалтын мэргэжилтэн бэлтгэсэн байна.<br>3-р улиралд: Шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авсан байна.<br>4-р улиралд: Холбогдох шийдвэр гаргуулах санал хүргүүлсэн байна. | | | Мөн шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтыг “Вертекс Мон ХХК”-тай “Тээврийн хэрэгслийн хяналтын төхөөрөмжид баталгаажуулалт хийх лабораторийн эталон төхөөрөмжийг нийлүүлэх” ХХАГ22/27 тоот гэрээг байгуулсан.<br>Гэрээний дагуу 2023.05.09-ны өдөр тахограф хэмжигч төхөөрөмжид шалгалт тохируулга гүйцэтгэх эталон тоног төхөөрөмжийн иж бүрдэл бүхий 14 төхөөрөмжөөс 12-г нь хүлээж авсан. Үлдсэн 2 төхөөрөмж нь ОХУ болон Украйны дайнтай холбоотойгоор тээвэрлэх үйл ажиллагаанд хүндрэл гарсан гэх шалтгаанаар 2023.10.01-нд нийлүүлэгдсэн.<br>ОХУ-ын НИААТ /Автотээврийн судалгааны хүрээлэн/-ээс зохион байгуулсан тахографын шалгалт, баталгаажуулалтын ажилтны цахим сургалтад мэргэжилтэн П.Эрхэмбаяр, жолоочийн сургалтад Ч.Сайнбаяр, хяналтын ажилтны сургалтад мэргэжилтэн Б.Баттогтох нар хамрагдсан.<br>2023.12.08-ны өдрийн байдлаар гэрээний дараах үүргүүд хангагдаагүй шалтгаанаар гэрээ дүгнээгүй байна. Үүнд:<br>1. Тоног төхөөрөмжүүдийн суурилуулалт хийгдээгүй.<br>2. Гэрээний үүргийн дагуу төхөөрөмжийн үйлдвэрлэгчийн байранд зохион байгуулах сургалтад мэргэжилтэн П.Эрхэмбаяр, Ч.Сайнбаяр, Б.Хишигболд нар хамрагдахаар бөгөөд эдгээр ажилтнуудын Англи улсад зорчих виз 2 удаа мэдүүлсэн боловч татгалзсан хариу авсан.<br>Эдгээр албан хаагчдын визний асуудлыг гадаад харилцааны шугамаар шийдвэрлүүлэх 1/1301 тоот албан бичгийг ЗТХЯ-нд хүргүүлсэн. | |
| **Зорилт 7: Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.** | | | | | |
| Техникийн хяналтын үзлэгийг тус яамтай байгуулсан “Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажил эрхлэх гэрээ”-ний дагуу гүйцэтгэх чиглэлээр | | | | | |
| 7.1 | 7.1.1 Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх үйл ажиллагааг жилийн турш жигд зохион байгуулж, замын хөдөлгөөнд оролцож буй нийт тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Өссөн дүнгээр 109648 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамруулсан байна.<br>**2-р улиралд:**<br>Өссөн дүнгээр 415492 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамруулсан байна | - | ТХХ | Техникийн хяналтын үзлэгийг суурин болон явуулын 53 төвөөр дамжуулан 2023.01.02-2023.12.10-ны өдрийн байдлаар 636847 тээврийн хэрэгсэл буюу 97.9%-ийн гүйцэтгэлтэй техникийн хяналтын үзлэгийг улсын хэмжээнд зохион байгуулан ажилласан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **3-р улиралд:**<br>Өссөн дүнгээр 567840 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамруулсан байна<br>**4-р улиралд:**<br>Өссөн дүнгээр 650390 тээврийн хэрэгсэл буюу нийт тээврийн хэрэгслийн 52%-ийг техникийн хяналтын үзлэгт хамруулсан байна. | | | | |
| | 7.1.2 Техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Төслийн хэрэгжилт<br>**Хугацаа**<br>II-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**2-р улирал:** Төслийн хэлэлцээрийг байгуулж, төлөвлөгөөг батлуулна.<br>**3-4-р улиралд:** Төслийн эхний шатны ажлыг хэрэгжүүлж эхэлнэ | БНСУ -ын Койка байгууллагын 13 сая долларын техникийн туслалцааны төсөл | ТХХ | 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр “Монгол улсын автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн чадавхыг бэхжүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах төсөл”-ыг хэрэгжүүлэх санамж бичгийг ЗТХ-н сайд, БНСУ-ын Тээврийн аюулгүй байдлын газрын ТУЗ-ын дарга нар байгуулахаар болсон.<br>2023 оны 09 сарын 25-ний “Монгол улсад хэрэгжүүлж буй Хөгжлийн албан ёсны төслийг хэрэгжүүлэх” төвөвлөгөө батлагдсаны дагуу төслийн хүрээнд 2023 оны 04-р улиралд:<br>- Бодлогын зөвлөмж<br>- Засварын гүйцэтгэгчийг шалгаруулах/ төлөвлөлт<br>- Тоног төхөөрөмжийг сонгох/ гүйцэтгэгчийг сонгон ажлууд хийгдэж байна. | |
| | 7.1.3 Иргэд ААНБ-уудад төрийн үйлчилгээг ойртуулах, үзлэгийн төвийн ачааллыг бууруулах зорилгоор Улаанбаатар хотын Хан-Уул, Сүхбаатар дүүрэгт техникийн хяналтын үзлэгийн төвийг шинээр байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Техникийн хяналтын үзлэгийн төв байгуулагдсан тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:** Техникийн хяналтын үзлэгийн төв байгуулах байр, газар, зай, талбайг судлах,<br>**2-р улиралд:** Техникийн хяналтын үзлэгийн төв байгуулах газартай гэрээ хийх,<br>**3-р улиралд:** Техникийн хяналтын үзлэгийн төвийн тоног төхөөрөмжийг суурилуулах, үйл ажиллагааг эхлүүлэх,<br>**4-р улиралд:**<br>Хан-Уул, Сүхбаатар дүүрэгт техникийн хяналтын үзлэгийн төв шинээр байгуулагдсан байна. | - | ТХХ | Нийслэлийн Хан-Уул дүүргийн 23-р хороо, Баянгол дүүрэг, 20-р хороо, Эрчим хүчний гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, газруудад судалгаа хийж 2023 оны 02 дугаар сарын 16-н ы өдрийн 1/201 албан тоот бичгээр “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар”т хүргүүлсэн бөгөөд 2023 оны 03 дугаар 07 өдрийн А-1/370 албан бичгээр тус газруудыг түрээслэхийг зөвшөөрсөн.<br>2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Олимпын гудамж “Таван богд” ХХК-тай №ТГ23/05 дугаартай ажлын байрны түрээсийн гэрээг байгуулсан.<br>2023 оны 05 дугаар сарын 05-ний өдөр Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Олимпын гудамж “Таван богд” ХХК-тай №ТГ23/05 дугаартай ажлын байранд Сүхбаатар техникийн хяналтын үзлэгийн төвийг байгуулсан. Тухайн төв нь 2023.05.05-09.20-ний өдрийн байдлаар 1554 тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулсан.<br>Зам, Тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/46 тушаалын дагуу 2023 оны 03 дугаар сарын 02-ний өдөр “Чингэлтэй техникийн үзлэгийн төв”, 2023 оны А/131 тушаалын дагуу 2023 оны 04 дүгээр сарын 27-ний өдөр “Цамбагарав техникийн хяналтын үзлэгийн төв”, 2023 оны А/142 тушаалын дагуу 2023.05.05-ны өдөр “Сүхбаатар техникийн хяналтын үзлэгийн төв”-ийн үйл ажиллагааг эхлүүлсэн. | |

| Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг зохих журамд заасны дагуу иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах чиглэлээр | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 7.2.1 Тээврийн хэрэгслийн торгууль, татварыг улсын дугаар авах үед ногдуулдаг асуудлыг зогсоож, зөрчил гаргасан иргэнд ногдуулдаг тогтолцоотой болгох талаар холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тогтолцооны өөрчлөлт<br>**Хугацаа**<br>I-II улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:** Холбогдох төрийн байгууллагуудтай уулзалт хийж, тодорхой шийдэл гаргасан байна.<br>**2-р улиралд:** Торгууль, татварыг зөрчил гаргасан иргэнд ногдуулдаг болсон байна. | - | ТХБХ | Зам тээврийн хөгжлийн сайдын 2020 оын А/222 тоот тушаалаар баталсан “Автотээврийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам”-д ЗТХЯ-ны АТБХЗГ-т 2023.03.06-ны өдрийн 1/245 тоот албан бичгээр 4.12 “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, хуулиар оногдуулсан торгуулийг тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийн регистрийн дугаараар шалгана” гэж оруулах санал боловсруулан хүргүүлсэн. Мөн Тээврийн цагдаагийн газартай 2023.01.23-ны өдөр, Татварын Ерөнхий газрын удирдлагуудтай 2023.02.08-ны өдөр тээврийн хэрэгслийн торгууль, татварыг улсын дугаар авах үед ногдуулдаг асуудлыг зогсоож, зөрчил гаргасан иргэнд ногдуулдаг тогтолцоотой болгох талаар уулзалт хурлыг зохион байгуулсан.<br>Цагдаагийн Ерөнхий газрын даргад 2022.11.22-ны өдрийн 1/1489 тоот албан бичгийг хүргүүлсэн. Цагдаагийн ерөнхий газраас манай байгууллагад хамтран ажиллах боломжтой талаар 2022.12.13-ны өдрийн 11/3218 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Тус газар сүлжээндээ холбогдох нэмэлт хөгжүүлэлтийн ажил хийгдэж эхэлсэн болно. Мөн Татварын ерөнхий газрын бүртгэлийн хэлтэс, мэдээллийн технологийн төвийн дарга, орлого төвлөрүүлэлтийн хэлтсийн дарга нартай 2023.02.08-ны өдөр уулзалт хийсэн бөгөөд тэдний зүгээс өөрсдийн сүлжээнд холбогдох хөгжүүлэлтийн хийн хамтран ажиллах тал дээр санал нэгдсэн. ЗТХС-ын 2023.05.04 ны өдрийн А/140 тоот тушаалаар холбогдох журамд нэмэлт өөрчлөлт орж баталсян. ЦЕГ, ТЕГ-т журмын хэрэгжилтийн ханган ажиллах талаар 2023.06.09-ны өдрийн 1/770, 2023.06.13-ны өдрийн 1/782 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн. Мөн ТЕГ-ийн мэдээллийн технилогийн хэлтсийн дарга, бүртгэлийн хэлтсийн дарга нартай 2023.06.15-ны өдөр журманд орсон нэмэлт өөрчлөлт түүнийг хэрэгжүүлэх холбогдох порграмманд хөгжүүлэлт хийж сервис харилцан солилцож хамтран ажиллах талаар уулзалт хийж санал нэгдсэн. 2023.09.18-ны өдөр ЦЕГ, ТЦГ, ЗХУТ-ийн холбогдох албан тушаалтануудтай уулзалт хийж журамд орсон нэмэлт өөрчлөлт болон хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцсон. ТЕГ, ЦЕГ өөрсдийн байгууллагын татвар, торгуулийн программд холбогдох хөгжүүлэлтийг хийж иргэн болон ААНБ-ын регистр болон бүртгэлийн дугаар дээр татвар торгуулийн ногдлыг холбон ажиллаж байна. | |
| | 7.2.2 Улсын хэмжээнд тээврийн хэрэгслийн эзэмшигч иргэн, ААНБ-ын шинэчилсэн бүртгэлийг зохион байгуулан явуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тээврийн хэрэгслийн мэдээлэл шинэчлэгдсэн байдал | - | ТХБХ | Зам Тээврийн Хөгжлийн Сайд, Сангийн Сайдын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээний тухай” А/57/48 дугаартай хамтарсан тушаал болон Зам Тээврийн Хөгжлийн Сайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Хугацаа**<br>I улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улирал**: Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл шинэчлэгдсэн байна. | | | баталсан “Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, үзлэг тооллогыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө” батлагдсан.<br>Дээрх тушаал, төлөвлөгөөний хүрээнд тус үйлдвэрийн газрын захирлын тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд 2023.03.13-нд ажлын төлөвлөгөөг баталсан. Техникийн хяналтын үзлэгт ороогүй тээврийн хэрэгслийн судалгааг сум баг хороо дүүргээр нэгтгэн гаргасан. Мөн Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллого зохион байгуулах зааварчилгаа, асуумжийг боловсруулан 2023.03.15-ны өдрийн 1/298, 1/299 тоот албан бичгээр 21 аймгийн засаг, нийслэлийн захирагчийн ажлын албанд хүргүүлсэн. Мөн тус үйл ажиллагааг цахим мэдээллийн хэрэгслээр явуулах Програм хангамжийн техникийн ажлын даалгаврыг боловсруулан тус үйлдвэрийн газрын Мэдээллийн технологийн хэлтэст 2023.03.14-ний өдөр хүргүүлсэн. Цахим хөгжлийн яамтай Мэдэгдэл хүргэх систем ашиглан үйлчилгээ үзүүлэх М-2023/4 гэрээг 2023.03.10-ны өдөр байгуулсан. 285000 орчим иргэнд мэдээллийг хүргэхээр жагсаалтыг гаргасан. ЗТХЯ-ны АТБХЗГ-ын даргад түр журам боловсруулах албан бичиг боловсруулан 2023.03.15-ны өдрийн 1/291 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2023.03.15-ны өдөр Орон нутгийн Автотээврийн төвийн дарга болон тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэргэжилтэн нартай цахим хурлыг зохион байгуулж үйл ажиллагааны талаар авч хэрэгжүүлж байгаа ажил болон зохион байгуулалтын талаар тодорхой нэгдсэн ойлголтийг өгсөн. ЗТХЯ-ны ТНБД болон АТБХЗГ-ын даргад тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл үзлэг тооллогын талаар авч хэрэгжүүлж байгаа ажил цаашид хийж хэрэгжүүлэх ажлын талаар 2023.03.10-ны өдөр танилцуулсан. Улсын хэмжээнд нийт **1,264,542** тээврийн хэрэгсэл шинэчилсэн бүртгэлд хамрагдахаас 2023.06.14-ний өдрийн байдлаар **1087251** тээврийн хэрэгсэл буюу **86** % хамрагдаад байна. 2023.06.19-ны өдөр ЗТХСайдын шуурхай дээр шинэчилсэн бүртгэлийн ажлын явц болон хийгдэж байгаа ажлын гүйцэтгэлийн талаар танилцуулсан. Уг ажил 2023.06.30-ны өдрийг хүртэл зохион байгуулан ажиллаж бөгөөд үйл ажиллагааны тайланг нэгтгэн гарган ЗТСайд, АТБХЗГ, тус үйлдвэрийн газрын улирдлагуудад танилцуулсан. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр иргэд олон нийтэд мэдээлэл хүргэсэн. Нийт 1264542 тээврийн хэрэгсэл шинэчилсэн бүртгэл дээр хамрагдахаас 1208891 буюу 96 хувь хамрагдсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 7.2.3 Тээврийн хэрэгслийн бүртгэлийн программд УБЕГ-ын сервесийг холбон иргэдэд цахимаар бүртгэлийн үйл ажиллагааг явуулах боломжийг бүрдүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмд УБЕГ-ын сервис холбогдсон байдал<br>**Хугацаа**<br>I-III улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Тээврийн хэрэгслийн бүртгэлийн программд УБЕГ-аас иргэн ААНБ-ийн холбогдох системийг холбох ажлыг эхлүүлсэн байна.<br>**2-р улиралд:**<br>Тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмд холбогдох байгууллагуудын сервистэй холбогдож мэдээлэл авдаг болсон байна. VRS системд нэмэлт хөгжүүлэлт хийсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Олон нийтэд хүргэж, сурталчилсан байна | - | ТХБХ<br>МТХ | ТХБХ:Тус үйлдвэрийн газраас Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 1/57 тоот албан бичгээр иргэний хувийн мэдээлэл, иргэний хаягийн мэдээлэл, иргэний регистрээр гар утасны дугаар шалгах, хуулийн этгээдийн мэдээлэл дамжуулах, хуулийн этгээдийн үйл ажиллгааны чиглэл зэрэг мэдээллийн сервисүүдийг ашиглах шаардлагатай байгаа талаар албан хүсэлт хүргүүлсэн. 2023.09.20-ны өддрийн байдлаар ТЕГ, ЦЕГ, Замын хөгжлийн төвтэй бүртгэлийн программ холбогдон ажиллаж байна.<br>МТХ: ЦХХХЯ-тай цахимаар мэдээлэл солилцох гэрээ байгуулан ажиллаж байна. УБЕГ-аас гэрээний хүрээнд мэдээлэл солилцох API сервис гаргаж өгөх бөгөөд холболтын ажлыг эхлүүлээд байна. | |
| | 7.2.4 Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системийг шинэчлэх санхүүжилтийг шийдвэрлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Шинэ систем нэвтрүүлсэн байдал<br>**Хугацаа**<br>I-III улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:** Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн шинэчлэх ажлын даалгавар гарч, санхүүжилтийг шийдвэрлэнэ.<br>**2-р улиралд:** Сонгон шалгаруулалтыг хийж, системийн хөгжүүлэлтийг эхлүүлнэ.<br>**3-р улиралд:**<br>Тээврийн хэрэгслийн бүртгэлийн шинэ системийг нэвтрүүлнэ | | ТХБХ<br>МТХ | Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн шинэчлэх ажлын даалгаварыг боловсруулан ЗТХЯ-нд хүргүүлсэн ба техник хяналтын цахим гэрчилгээ нэвтрүүлэх төслийн хүрээнд тус системийн шинэчлэлтийн санхүүжилтийн төсвийг суулгасан.<br>2023 оны 2-р улирлын байдлаар ЗТХЯ-нд шаардлагатай ажлын даалгаварыг боловсруулан хүргүүлсэн бөгөөд сонгон шалгаруулалт зарлагдсан. Гүйцэтгэгч байгууллага шалгарсны дараа Тээврийн хэрэгслийн бүртгэлийн систем болон архивын системийн хөгжүүлэлт хийгдэж эхлэнэ. | |
| **Зорилт 8: Тээврийн хэрэгсэл эзэмшигч, иргэн ААНБ-ын хариуцлагыг дээшлүүлж, хяналт шалгалтыг үр дүнтэй зохион байгуулж, зам, тээврийн осол түүнээс учирч буй хохирлыг бууруулна.** | | | | | |
| Ачаа, зорчигч тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тээврийн байгууллагад сахилга хариуцлагыг дээшлүүлэх, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулах чиглэлээр | | | | | |
| 8.1 | 8.1.1 Онцгой нөхцөл байдал буюу зам тээврийн осол, цаг агаар замын нөхцөл байдлын хүндрэл болон техникийн эвдрэл, гэмтлээс шалтгаалсан саатал, бүх нийтийг хамарсан халдварт өвчний улмаас хөдөлгөөн хязгаарлагдсан тохиолдлуудад зорчигчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр шуурхай ажиллагаа зохион байгуулах, нэгдсэн судалгаа гаргах<br>**Шалгуур үзүүлэлт** | - | ХУХ | Тайлант хугацаанд онцгой нөхцөл байдлын үед “Шуурхай ажиллагааны бүлэг”-ийн ажлын хэсэг 6 удаа ажиллаж, зорчигчдын амь нас, эрүүл мэндэд эрсдэл учирч болзошгүй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж, тээвэрлэлтийг шуурхай удирдлагаар хангах ажлыг зохион байгуулсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Зорчигчдын аюулгүй байдал хангагдсан байдал<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Тээвэрлэлтийн явцад гарсан осол, саатлын мэдээллийг холбогдох газруудад мэдэгдэн, осол саатлын нэгдсэн судалгааг гаргасан байна.<br>**2-4-р улиралд:**<br>Тээвэрлэлтийн явцад гарсан осол, саатлын үед шуурхай арга хэмжээ зохион байгуулж, зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангаж мэдээллийг холбогдох газруудад мэдэгдсэн байна. | | | Тээвэрлэлт гүйцэтгэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд зорчигчдын амь нас, эрүүл мэндийг болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор тээвэрлэлтийг зогсоож, ойр байрлах сум, суурин газарт байршуулах зохион байгуулалтыг хийж, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангаж ажилласан. Үүнд:<br>-Төлөвлөгөөт тээвэрлэлт гүйцэтгэх байсан давхарсан тоогоор 45 чиглэлийн 1555 зорчигчтой 122 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг эхлүүлэхгүйгээр түр хугацаагаар хойшлуулсан.<br>-Тээвэрлэлтийн хөдөлгөөнийг эхлүүлэн замд явж байсан 44 чиглэлийн 1721 зорчигчтой 49 тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг цааш үргэлжлүүлэхгүйгээр зогсоож, ойр байлах суурин газарт байршуулсан.<br>-Тээвэрлэлтийн хөдөлгөөнийг эхлүүлэн замд явж байсан 10 чиглэлд 320 зорчигчтой 11 тээврийн хэрэгслийг хөдөлгөөн эхлүүлсэн байршилд эргүүлэн татсан.<br>Зорчин явагчийн гэнэтийн ослын даатгалын байгууллагаас 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 95,000,000 төгрөг, үүнээс цаг агаар замын нөхцөл байдлаас шалтгаалсан саатлын үед **28,000,000** төгрөгийн нөхөн төлбөрийг шийдвэрлүүлж зорчигчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалан ажилласан. | |
| | 8.1.2 Тээвэрлэлтийн гэрээгүй нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчдэд хяналт шалгалт хийх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Зөрчлийн үзүүлэлтийн буурсан хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Гэрээгүй тээвэр эрхлэгчдийн судалгааг гаргасан байна.<br>**2-р улиралд:**<br>Гэрээгүй тээвэрлэлт эрхэлж буй жолооч болон түүгээр үйлчлүүлж буй иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байна.<br>**3-р улиралд:**<br>“Тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч тээвэр“-шугам замд шалгалт зохион байгуулсан байна.<br>**4-р улиралд:**<br>Гэрээгүй тээвэр эрхлэх зөрчил буурсан байна | - | ХУХ | Сар шинийн баярын өмнө орон нутаг, хот хоорондын хөдөлгөөн нэмэгдэж, хууль бус тээвэрлэлт ихсэхтэй холбогдуулан тус үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсоронзон, Тээврийн цагдаагийн албаны дарга, Цагдаагийн хурандаа Ц.Ариунболд нарын баталсан удирдамжийн дагуу 2023.02.09-02.20-ны өдрүүдэд хяналт шалгалт хийж, иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн үйлдвэрийн газрын Хөдөлгөөний удирдлагын хэлтэс, Ачаа тээврийн хэлтэс, Зорчигч тээврийн хэлтсийн мэргэжилтнүүд Сонгинохайрхан зорчигч тээврийн төвд хуваарийн дагуу хяналт шалгалтаар ажилласан.<br>2023 онд АТХУБ-ийн эрхийг 2023.02.18-ны өдөр авч 2023.03.17-ны өдөр шийтгэврийн хуудсыг авч ажилласан бөгөөд СХЗТТ, БЗТТ-өөс тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч 1364 иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Зөрчил давтан гаргасан иргэдэд ЗТХ-ийн дагуу торгуулийн арга хэмжээ авч ажиллаж байна. 2023.12.10-ны байдлаар тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлсэн 211 иргэнд ЗТХ-ийн 14.6-12 дахь заалтын дагуу 21,100,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. 78 тээврийн хэрэгслийн 208 зорчигчийг шилжүүлэн суулгасан. 2022 онд зөрчил давтан гаргасан 236 иргэн байсан бөгөөд 2023 онд зөрчил 10 хувиар буурсан.<br>Иргэдэд хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийг сонгож зорчих, зорчин явагчийн гэнэтийн ослын даатгалын ашиг тусыг | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | сурталчилан таниулахаар 50 баннер, зорчигчдод зориулсан тараах материал 30,000 ширхэгийг хэвлэн хот хоорондын зорчигч тээврийн автобуснууд болон тасалбар борлуулах цэгүүдэд байршуулахаас гадна олон нийтийн сүлжээгээр таниулан ажилласан.<br>Мөн "Даатгалтай зорчигч – Суудлын бүс" нэгдсэн арга хэмжээг ТЦА, даатгалын байгууллага, тээвэрлэгч ААНБ-уудтай хамтран 2023.07.03-ны өдрөөс 2023.07.06-ны өдрийн хооронд зохион байгуулсан бөгөөд хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслүүдээс гадна жуулчин тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, жолооч нарыг хамруулсан. Арга хэмжээний үеэр нийт 65 тээврийн хэрэгсэл, жолооч болон 1308 зорчигчдыг шалган хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, замын хөдөлгөөний дүрэм, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж зорчиж байсан 200 зорчигч, жолооч нарыг урамшуулсан.<br>"Хууль бус тээвэрлэлт осол зөрчил их дагуулдаг" нэр бүхий хот хоорондын зорчигч тээвэрлэлт гүйцэтгэгч, хууль бус тээвэрлэлт гүйцэтгэгчдийг харьцуулсан мэдээллийг 2023.04.18-ны өдрөөс эхлэн байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлан танилцуулсан. 2023.12.10-ны өдрийн байдлаар like 12716, 13318 удаа хуваалцсан байна. Тасал.мн сайтаар зорчигч тээврийн үйлчилгээтэй холбоотой 1 видео хийлгэн олон нийтэд түгээсэн. Түүнчлэн "Хууль бус тээвэрлэлтээс татгалзъя" сэдвээр 2 видео бичлэг, сэрэмжлүүлэг, зөвлөмж болгон нийт 15 постер бэлтгэн сошиал сувгаар олон нийтэд тогтмол сурталчилж байна.<br>2023-2024 оны хичээлийн жил эхэлж байгаатай холбогдуулан улс, хот хоорондын авто замд хот хоорондын нийтийн болон хувийн тээврийн хэрэгслээр зорчих иргэдийн хөдөлгөөн ихэссэн. Зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч ААНБ-ын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд 2023.08.21-ний өдрөөс 2023.09.15-ны өдрийн хугацаанд СХЗТТ, БЗЗТТ болон 21 аймгийн хэмжээнд хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласан. Тус хяналт шалгалтын хугацаанд хот хоорондын нийтийн зорчигч тээврийн 576 тээврийн хэрэгслийг шалгаж, тээвэрлэлтийн гэрээгүй зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлсэн 66 зөрчилд 6,600,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. | |
| | 8.1.3 Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаарын үйлчилгээг сайжруулах дуудлага алдагдлыг бууруулах зорилгоор өндөр ачаалалтай цагуудад иргэдэд үйлчлэх шугам нэмэх, орон нутгийн тээвэр зохицуулагч нараар мэдээлэл хүргүүлж ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт** | - | ХУХ | Автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаарын үйлчилгээ нь тасралтгүй 24 цагийн турш ажиллаж байгаа бөгөөд үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх ажлын хүрээнд 2023 оны 04 дүгээр сараас эхлэн Улаанбаатар хотын салбар, төвүүд болон 21 аймгийн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Дуудлага алдагдлыг бууруулсан хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Дуудлага ихээр орж ирдэг өндөр ачаалалтай цагуудад иргэдэд үйлчлэх шугамын тоог нэмэгдүүлнэ.<br>**2-р улиралд:**<br>Дуудлага алдагдлыг өмнөх оны мөн үеэс 5% бууруулсан байна.<br>**3-р улиралд:**<br>Иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанарыг сайжруулсан байна.<br>**4-р улиралд:**<br>Дуудлага алдагдал өмнөх онтой харьцуулахад 10-аас дээш хувиар буурсан байна | | | Автотээврийн төвүүдэд тус бүр нэг шугам шинээр нээн ажиллуулж байна. Оргил ачааллын цагт ажиллах шугамын тоог нэмэгдүүлсэнээр дуудлага алдагдлыг 20 хувь хүртэл бууруулсан байна.<br>2023.12.08-ны өдрийн байдлаар 1,474,196 дуудлага орж ирснээс 988,494 дуудлагад хариулт өгч, 27.12% дуудлага алдагдалтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 14.51%-иар буурсан. Лавлах үйлчилгээний тасаг – 744,439, Орон нутгийн салбарууд - 188,334, Улаанбаатар хотын салбар нэгж – 55,695 дуудлагад тус тус хариулт өгч үйлчилсэн байна. | |
| | 8.1.4 Салбар, төв, ААНБ-уудад зорчигч, ачаа тээвэр, мэргэшсэн жолоочийн шалгалтын үйл ажиллагааны талаар холбогдох эрх зүйн акт, төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан шийдвэрийн талаар сурталчлах, сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Зохион байгуулсан сургалтын тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан 1 сургалт зохион байгуулсан байна.<br>**2-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан 2 сургалт зохион байгуулсан байна.<br>**3-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан 3 сургалт зохион байгуулсан байна.<br>**4-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан 4 сургалт зохион байгуулсан байна. | 30 сая.төг | **ЗТХ**, АТХ | АТХ: “Автозамын ачаа тээврийн зохион байгуулалт” сэдвээр Механикийн тээврийн сургуультай хамтран тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад 2023.01.15-16-ны өдрүүдэд сертификаттай сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтыг 2 удаа цахимаар зохион байгуулж нийт 142 аж ахуйн нэгж байгууллагын 280 хүн хамрагдаж сертификат олгосон.<br>Мөн 2023.03.17-20-ны өдрийн хооронд Өмнөговь аймгийн Ханбогд суманд улс хооронд ачаа тээвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад “Улс хоорондын ачаа тээвэрлэлтийн зохион байгуулалт”-ын талаар нийт 434 аж ахуйн нэгж байгууллагын 512 ажилтанд сургалтыг зохион байгуулсан.<br>Автозамын ачаа тээвэрлэлт зохион байгуулалт” чиглэлээр 2023.06.21-2023.06.23-ны өдрүүдэд 54 ААНБ-ын тээвэр зохицуулагч 84 ажилтанд сертификат олгох сургалт зохион байгуулсан.<br>Монгол улсын нутаг дэвсгэрт тээвэрлэлт гүйцэтгэхэд аюулгүй ажиллагааны талаарх БНХАУ-ын 4, ОХУ-ын 6 жолоочид 2023.09.07-ны өдөр онлайнаар сургалт зохион байгуулсан.<br><br>ЗТХ: Улс, хот хоорондын нийтийн тээврийн жолооч нарт нийтийн тээврийн үйлчилгээний стандарт, дүрэм, журамд орсон өөрчлөлтүүдийн талаарх сургалтыг 2023.05.16 – 2023.09.22-ний өдрийн байдлаар бүсчлэн гэрээт 59 ААНБ-ын системд бүртгэлтэй 1477 жолоочид сургалтыг амжилттай зохион байгуулсан. | |
| | 8.1.5 Олон улсын, улсын чанартай авто замаар ачаа тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэл стандартын шаардлага хангаж эсэх болон даац хэтрэлтэд тавих хяналтыг сайжруулах, ЗТХЯ, мэргэжлийн хяналт, Тээврийн цагдаагийн албатай хамтран төлөвлөгөөт ажил зохион байгуулах | - | ХУХ | ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдын баталсан удирдамжийн дагуу ЗТХЯ, Тээврийн цагдаагийн алба, Орон нутгийн ЗЦГ-ын тасаг, Автотээврийн хяналтын улсын байцаагч нар 2023.03.02-08-ны өдрийг хүртэл Дархан-Уул, Орхон, Булган, | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Шалгуур үзүүлэлт**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран төлөвлөгөө батална.<br>**2-р улиралд**<br>Төлөвлөгөөт ажил 50-аас доошгүй хувь хэрэгжсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Төлөвлөгөөт ажил 70-аас доошгүй хувь хэрэгжсэн байна.<br>**4-р улиралд:**<br>Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна. | | | Хөвсгөл, Завхан, Архангай аймгуудын чиглэлийн авто замын дагуух байгууламжуудтай танилцаж, мэдээлэл авч ажилласан.<br>Тус аймгуудын чиглэлд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Могойн голын уурхай болон Өвөрхангай аймгийн Нарийн тээл сумын Баянтээгийн уурхайгаас нүүрс тээвэрлэлдэг аж ахуй нэгж байгууллага, иргэд жин тонн хэтрүүлэн тээвэрлэлт гүйцэтгэж байгаатай холбогдуулан газар дээр үзэж танилцан, авто замын хучилт, гүүрийн эвдрэл, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж байгааг таслан зогсоох, улсын чанартай авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангуулж, хяналт шалгалт тавих чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан.<br>Мөн Булган, Дорнод, Архангай, Баян-Өлгий, Дундговь, Дархан-Уул, Завхан, Сэлэнгэ аймгууд, Багахангай, Багануур дүүрэгт хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажилласан.<br>“Олон улс, улсын чанартай авто замын ашиглалт, замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”, “Зам, тээврийн хөгжлийн сайдаас хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч нартай хийсэн уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “АТҮТ” ТӨҮГ, “ЗТХТ” ТӨҮГ-тай хамтран хэрэгжүүлэх 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөө”-г тус тус батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>2023.12.10-ны байдлаар 9881 тээврийн хэрэгслийг шалгаж, 1291 зөрчил илэрснээс 769 зөрчлийг газар дээр нь арилгуулан жин тонн хэтрүүлсэн 522 зөрчилд 136,900,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан. | |
| | 8.1.6 ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Автотээврийн хяналтын чиглэлээр 2023 онд хамтран ажиллах төлөвлөгөө”-ний биелэлтийг хангаж ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:** Төлөвлөгөөнд тусгагдсан ажил 20-оос доошгүй хувь хангагдсан байна.<br>**2-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажил 50-аас доошгүй хувь хангагдсан байна.<br>**3-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажил 70-аас доошгүй хувь хангагдсан байна.<br>**4-р улиралд:** | - | ХУХ | ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, АТҮТ ТӨҮГ-ын захирал Б.Гүрсоронзон нарын баталсан Зам, тээврийн хөгжлийн яамнаас “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-тай байгуулсан ажил, үйлчилгээг хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8 дугаарт “төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн урьдчилан сэргийлэх шалгалтыг хэрэгжүүлэх” гэж нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус төлөвлөгөөний дагуу 11 ажил төлөвлөгдсөнөөс 10 ажил хэрэгжиж, 1 ажлыг 2024 онд хэрэгжүүлэхийг ЗТХЯ-ны СХГ-аас шийдвэрлэсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна | | | | |
| Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох ажлыг зохих журамд заасны дагуу аймаг, орон нутагт зохион байгуулах чиглэлээр | | | | | |
| 8.2 | 8.2.1 Авто үйлчилгээний байгууллагуудын судалгааг авч бүртгэлжүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Судалгааны дүн<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-2-р улиралд:**<br>Орон нутгийн авто үйлчилгээний байгууллагын 2023 оны судалгааг авч, нэгтгэн ЗТХЯ-нд тайлагнасан байна.<br>**3-р улиралд:**<br>Ирүүлсэн судалгаанд боловсруулалт хийнэ.<br>**4-р улиралд:**<br>Судалгааны үр дүнг яаманд тайлагнасан байна. | | АТХ | Авто үйлчилгээний байгууллагын судалгааг 2023 оны 03 дугаар сарын 09-22-ний өдрүүдэд авахаар загвар хүснэгтийг боловсруулан орон нутгийн АТТ-үүдэд хүргүүлсэн.<br>Булган, Ховд аймгийн Автотээврийн төвөөс бусад нь судалгааг хугацаандаа ирүүлсэн. Одоогоор 372 авто үйлчилгээ эрхлэгч судалгаанд хамрагдсан байна. Үүнээс техникийн үйлчилгээ завсарын чиглэлээр үйлчилгээ 29%, их бие засвар 8%, угаалга цэвэрлэгээ үйлчилгээ 24%, автотээврийн хэрэгсэл түүний сэлбэг, хэрэгсэл, эд ангийн худалдааны төрлөөр үйлчилгээний эрхлэгч 30%, автотээврийн хэрэгсэл, түүний эд анги хадгалах 13% тус тус үйлчилгээ эрхэлж байна.<br>Судалгаанд 433 авто үйлчилгээ эрхлэгч хамрагдсан бөгөөд судалгаанаас гарсан санал дүгнэлтийг боловсруулан 2023.05.26-ны өдрийн 1/725 тоот албан бичгээр ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн.<br>Судалгааны үр дүнг ЗТХЯ-нд тайлагнаж ажилласан. | |
| | 8.2.2 Ангилал тогтоох ажлыг аймаг орон нутагт зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Ангилал тогтоож, гэрээ байгуулсан ААНБ-ын тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-2-р улиралд:**<br>Орон нутагт 191 авто үйлчилгээний байгууллага ангилал тогтоолгож, үйлчилгээний төрлөөс хамааран 218 ангиллын гэрчилгээ авч гэрээ байгуулсан байна.<br>**3-4-р улиралд:**<br>Орон нутагт 197 авто үйлчилгээний байгууллага зохих журмын дагуу ангилал тогтоолгож, үйлчилгээний төрлөөс хамааран 224 ангиллын гэрчилгээ авч гэрээ байгуулсан байна. | - | АТХ | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээ эрхлэгчдэд өссөн дүнгээр **199** авто үйлчилгээний байгууллагад **235** ангиллын гэрчилгээ олгосон. Үүнд: Архангай 18, Баян-Өлгий 13, Баянхонгор 14, Булган 5, Говь-Алтай 10, Говьсүмбэр 12, Дархан-Уул 19, Дорноговь 10, Дорнод 4, Дундговь 2, Завхан 5, Орхон 24, Өвөрхангай 5, Өмнөговь 19, Сүхбаатар 17, Сэлэнгэ 7, Төв 4, Увс 10, Ховд 7, Хөвсгөл 10, Хэнтий 12, Замын-Үүд-6, Цогтцэций 2 байна. | |
| Мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох үйл ажиллагааг зохих журамд заасны дагуу зохион байгуулах чиглэлээр | | | | | |
| 8.3 | 8.3.1 Автотээврийн тухай хууль, ЗТБХБЯам, БСШУЯ-ны хамтарсан 2010 оны 161/229 тоот тушаалын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Мэргэшсэн жолоочийн шалгалт авч, үнэмлэх олгосон тоо<br>**Хугацаа** | - | ЗТХ-ийн МЖСТ | Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн 161/229 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2023.12.10-ны | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Мэргэшсэн жолоочийн 6500 удаагийн шалгалтыг авч, 2700 үнэмлэх хэвлэж олгосон байна.<br>**2-р улиралд:**<br>Мэргэшсэн жолоочийн 13000 удаагийн шалгалтыг авч, 5400 үнэмлэх хэвлэж олгосон байна.<br>**3-р улиралд:**<br>Мэргэшсэн жолоочийн 19500 удаагийн шалгалтыг авч, 8100 үнэмлэх хэвлэж олгосон байна.<br>**4-р улиралд:**<br>Мэргэшсэн жолоочийн 26000 удаагийн шалгалтыг авч, 10800 үнэмлэх хэвлэн олгосон байна. | | | өдрийн байдлаар 23113 жолоочоос давхардсан тоогоор 45677 удаа шалгалт авч 24111 жолооч шалгалт тэнцсэнээс 6624 мэргэшсэн жолоочийн үнэмлэх хэвлэж олгосон бөгөөд мэргэшсэн жолоочийн үнэмлэх цахим хэлбэрт шилжсэн бөгөөд 17487 цахим үнэмлэх олгож ажилласан. | |
| | 8.3.2 Автотээврийн хэрэгслийн Мэргэшсэн жолоочийн сургалт эрхлэх зөвшөөрөл олгож буй үйл ажиллагааг ил тод нээлттэй, стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллагад олгодог болох талаар холбогдох байгууллагатай зөвшилцөж, тодорхой ажил зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Шийдвэрлэсэн байдал<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-2-р улиралд:**<br>Эрх олгодог байгууллагад сургалтын эрх олгох үйл ажиллагаа болон сургалтын чанарыг сайжруулах асуудлаар санал хүргүүлсэн байна.<br>**3-4-р улиралд:**<br>Дээрх саналтай холбоотойгоор тодорхой ажил зохион байгуулсан байна. | - | МЖСТ | Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн 161/229 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох журам”-д өөрчлөлт оруулахаар ЗТХЯ, ХНХЯ, БШЯ болон бусад холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулагдаж ажиллаж байна. Мэргэшсэн жолоочийн сургалт явуулах эрх олгож буй үйл ажиллагаанд мэргэжлийн салбарын оролцоог хангах асуудлыг хэлэлцүүлсэн бөгөөд тухайн салбар хариуцсан ЗТХЯ мэргэшсэн жолоочийн сургалт эрхлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд түлхүү оролцдог байх талаар саналыг дэвшүүлж ихэнх төлөөлөл дэмжиж байгаа талаар саналаа хэлж тус журамд өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. | |
| | 8.3.3 Мэргэшсэн жолоочийн сургалт, бүртгэл, шалгалтын цахим программыг боловсронгуй болгох<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Цахим программ шинэчлэгдсэн байдал<br>**Хугацаа**<br>I-II улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Мэргэшсэн жолоочийн цахим программыг боловсронгуй болгох саналыг хүргүүлсэн байна.<br>**2-р улиралд:**<br>Мэргэшсэн жолоочийн цахим программ боловсронгуй болсон байна | - | МЖСТ<br>МТХ | Мэргэшсэн жолоочийн шалгалтын системийг хөгжүүлэх талаарх саналыг мэдээллийн технологийн хэлтэст хүргүүлж ажилласан бөгөөд үе шаттайгаар хийж гүйцэтгэн ажиллаж байна. Тухайлбал үнэмлэх сунгалтыг онлайн горимоор авах боломжийг бүрдүүлэн цаг хугацаа, орон зайнаас үл хамааран шалгалт өгөх, шалгалтын хураамжийг цахимаар төлөх боломжтой болсон.Мөн мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг цахим хэлбэрт оруулж E-mongolia системд байршуулаад байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 9: Хамтын ажиллагааг өргөжүүлж, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, эдийн засаг нийгмийн эрэлтэд нийцсэн, чанартай, шуурхай, аюулгүй, мэргэжлийн өндөр түвшний үйлчилгээг үзүүлж, тээврийн дэд бүтцийг хөгжүүлнэ.** | | | | | |
| Орон нутагт автотээврийн ажил үйлчилгээг хариуцан гүйцэтгэхдээ тухайн аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан хэрэгжилтийг хангуулах үр дүнг тооцох чиглэлээр | | | | | |
| 9.1 | 9.1.1 Аймгийн засаг даргатай байгуулсан гэрээг дүгнэх, үр дүнг тооцох<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Гэрээний хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-II улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-2-р улиралд:**<br>2021 оны гэрээг дүгнэж, үр дүнг тооцсон байна. | - | ЗСХНХ | Орон нутгийн автотээврийн төвүүдийн аймгийн засаг даргатай байгуулсан 21 гэрээг үр дүнг тооцож дүгнэсэн бөгөөд нийт гэрээний хэрэгжилт 90 хувиас дээш дүгнэгдсэн болно. | |
| | 9.1.2 Аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Гэрээ байгуулсан аймгийн тоо<br>**Хугацаа**<br>I-II улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-2-р улиралд:**<br>21 аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулагдсан байна. | - | ЗСХНХ | Аймгийн автотээврийн төвүүд тухайн орон нутгийнхаа Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулж ажилладаг бөгөөд 21 аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээг байгуулсан болно. | |
| Жил бүрийн зорилтот түвшинд авто буудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн барилга барих хөрөнгийг тусган батлуулж хэрэгжүүлэх, орон нутагт авто замын дагуух үйлчилгээний цогцолбор, тээвэр логистикийн төв, терминал барьж байгуулах чиглэлээр Аймгийн Засаг дарга нар болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлээр | | | | | |
| 9.2 | 9.2.1 Ховд болон Орхон, Говьсүмбэр аймагт автобуудлын барилгыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:** Говьсүмбэр аймгийн автобуудлын барилгыг барих гүйцэтгэгчийг сонгосон байна.<br>**2-р улиралд:**<br>Говьсүмбэр аймгийн автобуудлын барилгын ажлыг эхлүүлсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Барилга угсралтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгүүлсэн байна.<br>**4-р улиралд:**<br>3 аймгийн Автобуудлын барилгыг ашиглалтад оруулсан байна | Төр хувийн хэвшлийн түншлэл | ЗСХНХ | Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Орхон аймгийн автотээврийн төвийн автобуудлын барилгын ажлыг тус аймгийн орон нутгийн санхүүжилтээр 2022-2023 онд барьж байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг цахим хэлбэрээр 2022.01.18-ны өдөр зарлаж, 2022.02.18-ны өдөр нээсэн. Тендерт “Шинжүү” ХХК шалгарсан.<br>УТ-01/22 тоот гэрээний дагуу барилгын ажлыг 2022.05.18-ны өдөр эхлүүлсэн бөгөөд ажлын явц 85 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.<br>“Зорчигч тээврийн Ховд” ХХК нь өөрийн хөрөнгө оруулалтаар Ховд аймагт автобуудал барьж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90%-тай байна.<br>Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Говьсүмбэр аймгийн автобуудлын барилгыг барих талаар үйлдвэрийн газраас ТӨБЗГ-т хүсэлт гаргасан бөгөөд ЗТХЯ-наас дэмжлэг авч, шийдвэрлүүлэх чиглэл өгсөн. ЗТХЯ-нд 2023.03.21-ний өдрийн 1/325 тоот албан | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | бичгээр хүсэлт хүргүүлсэн бөгөөд барилгын ажил эхлээгүй газрын асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. | |
| | 9.2.2 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Байгуулсан цогцолборын тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Хүсэлт, саналуудыг нэгтгэж, санал дүгнэлт гаргах, шалгаруулна.<br>**2-р улиралд:**<br>Зөвлөгөө, дэмжлэг үзүүлнэ.<br>**3-р улиралд:**<br>Барилгын ажлыг гүйцэтгэсэн байна.<br>**4-р улиралд:**<br>Авто зам дагуух үйлчилгээний 2 цогцолбор байгуулсан байна. | Төр хувийн хэвшлийн түншлэл | ЗТХ ЗСХНХ | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах талаарх судалгааг хийн ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн. Үүнээс нийт 47 байршил байгуулах санал БОЯЖЯ болон ЗТХЯ-ны хамтарсан ажлын хэсгээс гарсан бөгөөд ЗТХЯ-наас 47 байршилд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Хүсэлт гаргасан болон сонгон шалгаруулалтын талаар мэдээлэл авахыг хүссэн 20 аж ахуй нэгж байгууллагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн бөгөөд 47 байршлаас 2023 онд ашиглалтад орсон 6 байршлын аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран дэмжин ажиллаж байна. | |
| | 9.2.3 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу үйлчилгээний цогцолбор байгуулсан ААНБ-уудыг бодлогоор дэмжих, хамтран ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>“Хамтран ажиллах гэрээ байгуулсан” ААНБ-ын тоо-4<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд: Улсын чанартай** авто замын дагуу үйлчилгээний цогцолбор байгуулсан ААНБ болон хот хоорондын нийтийн тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэгч ААНБ хооронд гурвалсан “Хамтран ажиллах” гэрээ байгуулсан байна.<br>**2-4-р улиралд:** Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээний биелэлтийг хангуулсан байна.<br>**Жилийн эцэст:** Стандартын шаардлага хангасан авто зам дагуух үйлчилгээний цогцолборуудыг дэмжих бодлого хэрэгжсэн байна. Гэрээг дүгнэж үр дүнг тайлагнасан байна. | Төр хувийн хэвшлийн түншлэл | ЗТХ | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд улсын чанартай авто замын дагуу 150-200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах талаарх судалгааг хийн ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн. Үүнээс нийт 47 байршил байгуулах санал БОЯЖЯ болон ЗТХЯ-ны хамтарсан ажлын хэсгээс гарсан бөгөөд ЗТХЯ-наас 47 байршилд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Хүсэлт гаргасан болон сонгон шалгаруулалтын талаар мэдээлэл авахыг хүссэн 20 аж ахуй нэгж байгууллагад зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн бөгөөд 47 байршлаас 2023 онд ашиглалтад орсон 6 байршлын аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран дэмжин ажиллаж байна. | |
| **Стратегийн зорилт 10: Автотээврийн салбарын судалгаа, шинжилгээний ажлыг хийж, чанарын дэд бүтцийг бэхжүүлэн, техникийн сорилт туршилт, баталгаажуулалт хийнэ.** | | | | | |
| Засгийн газраас хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөр болон салбарын яамнаас баримталж буй бодлого, чиглэлийн хүрээнд судалгааны ажил хийх чиглэлээр | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 10.1 | 10.1.1 Зам, тээврийн хөгжлийн яамны захиалгаар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус судалгааны ажил хийх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Судалгааны ажлын тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-4-р улиралд:**<br>Судалгаа хийж, яаманд хүргүүлсэн байна. | | СХЧУТ | Автотээврийн хэрэгсэлд суурилуулах утаа шүүгчийг дотоодод үйлдвэрлэх боломж" зөвлөх үйлчилгээний эцсийн шатны тайланг ЗТХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дэргэдэх Автотээврийн салбарын шинжлэх ухаан технологийн дэд зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 09-ны хурлаар хэлэлцэн 11 сайжруулах зөвлөмжийг ирүүлсэн.<br>Зөвлөмжийн хүрээнд саналыг тусган эцсийн шатны тайланг гэрээнд заасан хугацаанд буюу 2023 оны 07 сарын 07-ны 1/969 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. | |
| | 10.1.2 Ашиглалтаас хасагдсан автомашин, түүний эд ангийг устгах, дахин боловсруулах талаар санал боловсруулах, судалгааны ажил хийх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Судалгааны үр дүн<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Ашиглалтаас хасагдсан автомашин, түүний эд ангийг устгах, дахин боловсруулах судалгааны ажлыг эхлүүлнэ.<br>**2-р улиралд:**<br>Хийгдсэн судалгааны дагуу холбогдох мэргэжлийн байгууллагуудаас санал авч боловсруулалт хийнэ.<br>**3-р улиралд:**<br>Дүн шинжилгээ хийнэ.<br>**4-р улиралд:**<br>Судалгааны тайланг яаманд хүргүүлсэн байна. | - | АТХ | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй авто үйлчилгээний эрхлэгчдийн ажил үйлчилгээнээс үүсч буй хог хаягдлын судалгааг 2023.03.09-262-ны өдрүүдэд авахаар загвар хүснэгтийг боловсруулан орон нутгийн АТТ-үүдэд хүргүүлсэн. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 433 авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүсч байгаа хог хаягдлын судалгааг авч, холбогдох саналыг боловсруулан 2023.05.26-ны өдрийн 1/725 тоот албан бичгээр ЗТХЯ-ны АТБХЗГ-т хүргүүлсэн. | |
| | 10.1.3 Үйлдвэрийн газрын ажилтнууд болон хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, дүнг танилцуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Судалгаа хийж, танилцуулсан байдал<br>**Хугацаа**<br>I улирал<br>**Зорилтот түвшин**<br>1-р улиралд: Судалгааг авч, захиралд танилцуулсан байна. | - | СХЧУТ | Судалгааны мэдээллийг онлайн болон цаасан хэлбэрээр цуглуулан нийт 333 ажилтан, 516 үйлчлүүлэгч хамрагдсан. Судалгааны үр дүнд үйлдвэрийн газраар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн индекс дундаас дээгүүр (6-7.4) байна. Иймд бид үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг жилд нэг удаа бус тогтмол хийж хангалтгүй үнэлгээ авсан үйл ажиллагааны чиглэлээр тухай бүр тодорхой ажил сайжруулах төлөвлөгөө гарган үйлчилгээний чанарыг байнга сайжруулж ажиллах шаардлагатай гэсэн санал зөвлөмжийг дуусган захиралд танилцуулсан. | |
| Гэрээний үндсэн дээр хариуцуулан гүйцэтгэх ажил үйлчилгээг шуурхай зохион байгуулах зорилгоор бусад холбогдох эрх зүйн акттай уялдуулж шаардлагатай дүрэм, журам, стандартыг шинээр боловсруулах, шинэчлэн сайжруулах чиглэлээр санал гаргах, холбогдох дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх чиглэлээр | | | | | |
| 10.2 | 10.2.1 Автотээврийн салбарын чанарын дэд бүтцийг бэхжүүлэх чиглэлээр 2 стандарт шинээр боловсруулах.<br>**Шалгуур үзүүлэлт** | - | СХЧУТ | Тайлант хугацаанд дараах стандартуудыг боловсруулж СХЗГ-т хүргүүлсэн ба тус газрын даргын 2023 оны С/22 дугаар тушаалаар үндэсний стандартаар баталсан байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Боловсруулсан стандартын тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Стандартуудын төсөлд редакцийн саналыг тусгасан байна.<br>**2-р улиралд:**<br>Сонирхогч талуудаас санал авсан байна.<br>**3-р улиралд:**<br>Сонирхогч талуудын саналыг тусгасан төслийн эцсийн найруулгыг хийсэн байна.<br>**4-р улиралд:**<br>2 стандартын төслийг СХЗГ-т хүргүүлсэн байна. | | | ○ MNS 7008:2023 Албадмал ноцоолттой хөдөлгүүрийн ажилласан хийн хорт бодисын агууламжийг тодорхойлох хэмжих хэрэгсэл. Шалгах арга хэрэгсэл<br>○ MNS 7009:2023 Автотээврийн хэрэгслийн шахалтаар ноцоодог хөдөлгүүрийн ажилласан хийн тортогжилт болон гэрэл шингээлтийн итгэлцүүрийг тодорхойлох хэмжих хэрэгсэл. Шалгах арга, хэрэгсэл<br>○ MNS 7010:2023 Автотээврийн хэрэгслийн их гэрлийн хэмжил зүйн үзүүлэлтийг хэмжих хэрэгсэл. Шалгах арга, хэрэгсэл<br>MNS 7011:2023 Автотээврийн хэрэгслийн урд тэнхлэгийн хажуу гулсалт хэмжих хэрэгсэл. Шалгах арга, хэрэгсэл | |
| | 10.2.2 MNS 4599 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд стандартад нэмэлт өөрчлөлт оруулах,<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Нэмэлт өөрчлөлт оруулсан байдал<br>**Хугацаа**<br>I-III улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-2-р улиралд:**<br>Стандартын төслийг боловсруулсан байна.<br>**3-р улиралд:**<br>Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн байна | - | ТХХ | MNS 4599 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд стандартад нэмэлт өөрчлөлт оруулан боловсруулж “Хууль, Зүй дотоод хэргийн яам” “Тээврийн цагдаагийн алба”, “Зам, тээврийн хөгжлийн яам”, “Нийслэлийн тээврийн газар”, “ШУТИС-Механик тээврийн сургууль”-д MNS 4599 Автотээврийн хөдлөх бүрэлдэхүүний эргономикийн үзүүлэлтүүд стандартад нэмэлт өөрчлөлт оруулах стандартын төсөлд санал авахаар албан тоотыг хүргүүлсэн. | |
| Автотээврийн салбарын ажил үйлчилгээнд баталгаат үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр | | | | | |
| 10.3 | 10.3.1 Нийтийн зорчигч тээвэр, ачаа тээвэр, болон автотээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуй нэгж, байгууллагад тохирлын үнэлгээ хийх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тохирлын үнэлгээ хийсэн ААНБ-ын тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Хүсэлт ирүүлсэн 6-аас доошгүй ААНБ-д тохирлын үнэлгээ хийсэн байна.<br>**2-р улиралд:**<br>Өссөн дүнгээр хүсэлт ирүүлсэн 12-аас доошгүй ААНБ-д тохирлын үнэлгээ хийсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Өссөн дүнгээр хүсэлт ирүүлсэн 20-иас доошгүй ААНБ-д тохирлын үнэлгээ хийсэн байна.<br>**4-р улиралд:** | - | СХЧУТ | Тайлант хугацаанд 187 хүсэлтийн дагуу 167 ААН-д үнэлгээ хийж, схемийн шаардлагыг хангасан нийтийн зорчигч тээврийн 11, автотээврийн хэрэгслийн засвар 9, ачаа тээврийн үйлчилгээний 137 нийт 157 аж ахуйн нэгжид тохирлын гэрчилгээ олгож, схемийн шаардлага хангаагүй 11 ААН-д гэрчилгээ олгохгүй шийдвэр гарсан. 16-н ААН-д үл тохирлыг залруулах 3 сар хүртэлх хугацаа өгөөд байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Өссөн дүнгээр хүсэлт ирүүлсэн 29-өөс доошгүй ААНБ-д тохирлын үнэлгээ хийж, олон нийтэд ил тод мэдээлсэн байна. | | | | |
| | 10.3.2 Салбарын хэмжээнд ашиглагдаж байгаа хэмжих хэрэгсэлд Олон улсын нэгжийн СИ системийн дагуу нэгж дамжуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Шалгалт тохируулга хийсэн хэмжих хэрэгслийн тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>50-иас багагүй хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн байна.<br>**2-р улиралд:**<br>Өссөн дүнгээр 100-аас багагүй хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Өссөн дүнгээр 200-аас багагүй хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн байна.<br>**4-р улиралд:**<br>Өссөн дүнгээр 286-аас багагүй хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийсэн байна. | - | СХЧУТ | Тайлант хугацаанд үйлдвэрийн газрын Улаанбаатар хотын 7, орон нутгийн 22 салбарын техникийн хяналтын үзлэгийн төвийн 315 ширхэг, хувийн хэвшлийн 7 ААНБ-ын 49 ширхэг, нийт 471 ширхэг тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийж, хэмжлийн үр дүнг үндэслэн шалгалт тохируулгын гэрчилгээ олгосон. | |
| Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, түүнд нийцүүлэн гарсан дүрэм, журам, стандартыг, мөрдүүлж, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр | | | | | |
| 10.4 | 10.4.1 “ХАБЭА-н мэдлэг олгох ажил олгогч болон нийт ажилтны сургалт” зохион байгуулах.<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Сургалтад хамрагдсан ажилтны тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаанд 350 ажилтан хамрагдаж, төлөвлөгөө батлуулж, хичээлийн бэлтгэл ажил хангагдсан байна.<br>**2-р улиралд:**<br>Сургалтанд 200 ажилтан хамрагдсан байна.<br>**3-р улиралд:**<br>Сургалтанд өссөн дүнгээр 400 ажилтан хамрагдсан байна.<br>**4-р улиралд:**<br>Сургалтанд өссөн дүнгээр 800 ажилтан хамрагдсан байна. | - | СХЧУТ | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгох ажил олгогч болон нийт ажилтны сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаанд нийт 498 ажилтныг хамруулж 2023 оны ХАБЭА-н сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, батлуулсан. Нийслэлийн онцгой байдлын газрын харьяа “Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв” -д 2023 оны 01 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд үйлдвэрийн хэлтэс, төвүүдийн 308 ажилтнуудыг “Гамшиг, аюул ослын үед өөрийгөө болон бусдыг аврах, хамгаалах, урьдчилан сэргийлэх” анхан шатны мэдлэгийг эзэмших сургалтад хамруулсан.<br>Тайлант хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг олгох нийт ажилтны сургалтад үйлдвэрийн газрын 654 албан хаагч, хот хоорондын зорчигч тээврийн 8 аж ахуй нэгж, улс хоорондын ачаа тээврийн 2 аж ахуй нэгж байгууллагын нийт 197 ажилтан хамрагдаж, гэрчилгээг олгосон. | |
| | 10.4.2 ЗТХЯ-аас гаргасан шалгуур үзүүлэлт бүрийн дагуу үйлдвэрийн газраас 2023 онд ХАБЭА-н чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, шаардлагатай нөөцөөр ханган хэрэгжилтийг тухай бүр тайлагнах. | - | СХЧУТ | Үйлдвэрийн газраас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 2023 онд 17 ажил хийж хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100% хэрэгжүүлсэн 14, хэрэгжилтийн шатандаа буюу 90%-н гүйцэтгэлтэй 3 ажил байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Шалгуур үзүүлэлт**<br>Хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг хангуулах ажлыг эхлүүлсэн байна.<br>**2-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлт 40-өөс доошгүй хувь хангагдсан байна.<br>**3-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлт 70-аас доошгүй хувь хангагдсан байна.<br>**4-р улиралд:**<br>2021 оны зорилтот ажлуудын биелэлт 90-ээс доошгүй хувь хангагдсан байна. | | | Төлөвлөгөөний гүйцэтгэл 4-р улирлын байдлаар 98 хувьтай. | |
| **Зорилт 11: Шинэ сэргэлтийн бодлогын эхний үе шатны төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд автотээврийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлнэ**. | | | | | |
| "Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын дагуу автотээврийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлэх чиглэлээр | | | | | |
| 11.1 | 11.1.1 Дотоодын ачаа тээврийг бүртгэлжүүлэх, програм хангамжийг улсын хэмжээнд нэвтрүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Системийн нэвтрүүлэлтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Дотоодын ачаа тээврийн цахим системийн гар утсанд суурилсан хувилбарыг ашиглах бэлтгэл ажлыг хангасан байна.<br>**2-р улиралд:**<br>Дотоодын ачаа тээврийн цахим системийн гар утсанд суурилсан хувилбарыг үйлчилгээнд туршсан байна.<br>**3-р улиралд:**<br>Дотоодын ачаа тээврийн үйлчилгээг эхлүүлсэн байна.<br>**4-р улиралд**<br>Системүүдийг 100% үйлчилгээнд бүрэн нэвтрүүлсэн байна. | Төр хувийн хэвшлийн түншлэл | АТХ МТХ | Дотоодын ачаа тээврийн logistic.transdep.mn програм хангамжийг боловсруулан **2021.04** дүгээр сард вэб хувилбарыг нэвтрүүлсэн мөн мобайл гар утасны аппликейшинийг **2022.03-р** сард андройд гар утсанд зориулагдсан хувилбарыг "Playstore"-д байршуулан ашиглаж байна. Хот хоорондын ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, ачааны төрлийн тээврийн хэрэгслийг www.logistic.transdep.mn сайтаар дамжуулан хянах боломжийг бүрдүүлэн ажиллах, ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх, мэдээллийн сан үүсгэх ажлыг идэвхжүүлэх чиглэлээр санал солилцох онлайн хурлыг 2023 оны 03 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд дээрх хурлаас системийг шинэчлэх шаардлага үүссэн бөгөөд орон нутаг салбар төвүүдээс ирсэн саналыг нэгтгэсэн. Системийн шинэчлэл 80%-ийн гүйцэтгэлтэй байна.<br>2023 оны 12 сарын 10-ний байдлаар:<br>1.УБ-Даланзадгад-УБ чиглэлд "Буян цог оршвой ХХК"-тай 1 жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллаж байна. 2023 оны 12 сарын 10-ний өдрийн байдлаар **110,6** тонн ачааг бүртгэлжүүлэн хяналт тавьж ажиллаж байна.<br>2. УБ-Хөвсгөл-УБ чиглэлд "Нөхөрлөл зам", "Наран логистик" ААН-үүдтэй 2023 оны 01 дүгээр сард түр хугацааны сарын | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хугацаатай гэрээ байгуулсан. Мөн 2023 оны 05 дугаар сард “Хос билэг девелопмент энд констракшн” ХХК, “Чингүн хурд транс” ХХК тус тус гэрээ байгуулан 2023.12.10-ны байдлаар **722** тонн ачааг бүртгэлжүүлэн хяналт тавьж ажиллаж байна.<br>**МТХ**: Дотоодын ачаа тээврийн бүртгэлийн logistic.transdep.mn системийг 2021 оны 3-р сард ашиглалтанд оруулан үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн. Хот хоорондын ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, ачааны төрлийн тээврийн хэрэгслийг www.logistic.transdep.mn сайтаар дамжуулан хянах боломжийг бүрдүүлэн ажиллах, ачаа тээвэрлэлтийг бүртгэлжүүлэх, мэдээллийн сан үүсгэх ажлыг идэвхжүүлэх чиглэлээр санал солилцох онлайн хурлыг 2023 оны 03 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд дээрх хурлаас системийг шинэчлэх шаардлага үүссэн бөгөөд орон нутаг салбар төвүүдээс ирсэн саналыг нэгтгэн 2023 оны 4-р улиралд багтаан logistic.transdep.mn сайтыг өөрчлөлт шинэчлэлт хийхээр ажиллаж байна. Системийн шинэчлэл 80%-ийн гүйцэтгэлтэй байна. | |
| | 11.1.2 Улс хоорондын байнгын ачаа тээврийн зөвшөөрлийг “e-mongolia” порталаар олгох нөхцөлийг бүрдүүлэх;<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Систем нэвтрүүлэлтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд**<br>Гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ-ын гүйцэтгэх захирлын мэдээллийг Гадаадын иргэн харъяатын газраас тодруулж авсан байна.<br>**2-р улиралд**<br>Зөвшөөрлийг И-Монгол порталаар дамжуулан олгож эхэлсэн байна.<br>**3-4-р улиралд**<br>Системийг 100% үйлчилгээнд нэвтрүүлж, Зөвшөөрлийг И-Монгол порталаар олгосон байна | 40.0 сая төгрөг /Улсын төсөв/ | АТХ<br>МТХ | Улс хоорондын байнгын ачаа тээврийн хил нэвтрэх зориулалттай “С” төрлийн зорчих зөвшөөрлийн бичгийг “e-mongolia” порталаар олгох талаар 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр Е-Монголиа академийн холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, түгээмэл асуугддаг асуулт, танилцуулга мэдээлэл, ачааны төрөл, уурхай нэмэх зэрэг мэдээллийг шинэчилсэн.<br>Хэрэглэгчдэд зориулсан танилцуулга шторкыг “И-Монголиа” порталаас гаргахаар болсон ба програм хангамжийг дахин сайжруулах чиглэлээр зарим хөгжүүлэлтийг хийхээр болсон.<br>2023 оны 03 дугаар сарын 03-ны өдөр “И-Монголиа”-ын академи дээр хамтарсан уулзалт зохион байгуулж С зөвшөөрлийг олгох туршилт тохируулгыг хийсэн боловч мэдээлэл солилцох явцад алдаа гарч, хөгжүүлэлт дахин хийхээр болж 2023 оны 2-р улиралд багтаан үйлчилгээнд нэвтрүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.<br>Систем хөгжүүлэлтийн ажил 80%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Засгийн газрын 362 тогтоолийн 5 дугаар зүйлд заасан Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд ашигт малтмалыг уурхайн ам нөхцөлөөр борлуулах шинэ гэрээ байгуулахыг зогсоож, хилийн үнээр худалдан борлуулах, байнгын ачаа тээврийн хил нэвтрэх С төрлийн зорчих зөвшөөрлийг олгох эрхийг олборлолтын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдэд шилжүүлэх хэрэгжилтийн хүрээнд зам тээврийн хөгжлийн яамтай байгуулсан ажил, үйлчилгээ хариуцуулан гүйцэтгүүлэх гэрээг хэрэгжүүлэх 2023 оны үйл ажиллагааны | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлөвлөгөөний 11.1.2-т заасан хэсгийг хасуулах саналыг 2023 оны 10 дугаар сарын 04-ны өдөр 1/1264 тоот албан бичгээр Зам тээвэр хөгжлийн яаманд хүргүүлсэн. | |
| | 11.1.3 Мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг цахимжуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг цахимаар хүлээн авсан жолооч нарын тоо<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Журмын төслийг боловсруулсан байна.<br>**2-р улиралд:**<br>Журмын төслийн саналыг яаманд хүргүүлсэн байна.<br>**3-р улиралд:**<br>Журам шинэчлэн батлагдсан тохиолдолд үнэмлэхийг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг эхлүүлнэ.<br>**4-р улиралд:**<br>Мэргэшсэн жолоочийн үнэмлэх цахим болсон байна. | - | МЖСТ<br>МТХ | Монгол Улсын Засгийн газраас “Цахим Үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд "Зам, тээврийн хөгжлийн яам", "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ нь автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг цахим хэлбэрт шилжүүлж “E-Mongolia” системд 2023.05.26-ны өдөр албан ёсоор нэвтрүүлээд байна. Цаашид мэргэшсэн жолоочийн үнэмлэхийг E-Mongolia системд нэвтрэн цахимаар ашиглах боломжтой болсон. Монгол улсад бүртгэлтэй мэргэшсэн жолоочийн бүхий л цахим мэдээллийг байршуулсан. | |
| | 11.1.4 Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID)-г бүрэн нэвтрүүлж, татвар даатгал, төлбөр тооцоо, бүртгэл хяналтын үйл ажиллагааг сайжруулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашинд RFID ялтсыг суурилуулсан хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1--р улиралд:**<br>Албан журмын даатгагчдын холбооноос RFID ялтас хүлээн авсан байна.<br>**2-р улиралд:**<br>Суурилуулах бэлтгэл ажлыг хангасан байна.<br>**3-р улиралд:**<br>Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автомашины 50-аас доошгүй хувьд RFID ялтсыг суурилуулсан байна.<br>**4-р улиралд:**<br>Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашинд RFID ялтсыг суурилуулсан байна | - | ТХХ<br>МТХ | Улаанбаатар хотын хэмжээнд нийт 166 байршил, олон улс, улсын чанартай авто замын нийт 33 төлбөр авах цэгт RFID уншигч болон LPR дугаар танилтын камерын систем суурилуулахаар төлөвлөж нийслэлийн хэмжээнд RFID уншигч төхөөрөмжийг суурилуулах ажлыг хийж гүйцэтгээд байна.<br>Төрийн үйлчилгээ хурдан шуурхай хүргэх, тээврийн хэрэгслийн мэдээллийг цахимжуулах, шинэчилсэн бүртгэлд хамтруулах, авто замын хөдөлгөөн зохион байгуулалт болон зохицуулалтыг автомат хэлбэрт шилжүүлэх, тээврийн хэрэгслийг дата загварт оруулах, олон улсад амжилттай хэрэгжиж, туршигдсан RFID (Radio-frequency identification) болон дугаар таних LPR технологиудыг ашиглан, хэрэгжүүлж эхлээд байна.<br>“Автотээврийн Үндэсний Төв” ТӨҮГ-ын хувьд техник хяналтын цахим гэрчилгээний загвар тодорхойлох, шошгоны техникийн шаардлага боловсруулах ажлын хэсэгт хамтран ажиллаа.<br>1. ТЕХНИК ХЯНАЛТЫН ХЭРЭГСЛИЙН ЦАХИМ ГЭРЧИЛГЭЭНИЙ RFID ШОШГОНЫ СУДАЛГАА<br>Тус үйлдвэрийн газрын Мэдээллийн Технологийн Хэлтэс нь Нийслэлийн мэдээллийн технологийн газар болон Бодь-Электроникс ХХК-тай хамтран RFID шошго судлах ажлын хүрээнд БНХАУ-ын Шанхай хотноо шошго үйлдвэрлэгчийн шошгыг судлаж тестлэх ажлыг хамтран гүйцэтгэлээ.<br>2. RFID ШОШГО БҮРТГЭЛИЙН СИСТЕМ | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Тус үйлдвэрийн газрын Мэдээллийн Технологийн Хэлтэс нь RFID шошго бүртгэлжүүлэх гар утасны апп хөгжүүлсэн бөгөөд тус систем нь автотээврийн хэрэгслийн цонхонд байршуулсан шошгыг уншигч төхөөрөмжөөр таниулан тухайн тээврийн хэрэгслийн мэдээллийг шалган бүртгэлжүүлэх бөгөөд тухайн тээврийн хэрэгсэлд шошго суурилуулсан фото зураг авч баталгаажуулан бүртгэл үүсгэн ажиллаж байна.<br>3. RFID ШОШГО БҮРТГЭЛЖҮҮЛЭХ АЖИЛ<br>Тус үйлдвэрийн газар нь Түгжрэлийг бууруулах үндэсний хороо болон Нийслэлийн Мэдээллийн Технологийн Газартай хамтран өөрсдийн хөгжүүлсэн бүртгэлийн системээр нийслэлийн үйлчилгээний автобаазын 43 тээврийн хэрэгсэлд RFID шошго байршуулан ажилласан бөгөөд Иргэний Нисэхийн Ерөнхий Газрын 87 тээврийн хэрэгсэлд шошго байршуулан туршилт тохируулгын ажил хийж гүйцэтгээд байна.<br>4. RFID ШОШГО БҮРТГЭЛЖҮҮЛЭХ ХАМТЫН АЖИЛЛАГАА<br>Тус үйлдвэрийн газар нь ЗТХЯ, Түгжрэлийн бууруулах Үндэсний Хороо, НМТГ, Бодь-Электроникс ХХК зэрэг байгууллагуудтай туршилт тохируулгын ажлыг хамтран гүйцэтгэн ажилласан бөгөөд RFID шошго суурилуулах ажил дээр “Бодь-Электроникс” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан өөрсдийн суурин 33 цэг, явуулын 11 цэгээр нийт 126 ажилтан албан хаагчаар 447,200 орчим шошгыг Улаанбаатар хотын харьяалал бүхий тээврийн хэрэгсэлд байршуулахаар гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. 2023 оны 12-р сарын 11-ний өдрийн байдлаар 75.724 цахим гэрчилгээг Улаанбаатар хотын 7 ТХҮТ-ийн салбаруудаар суурилуулаад байна.<br>**БИЕЛЭЛТ 100%** | |
| | 11.1.5 Автотээврийн хэрэгслийн гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Цахим гэрчилгээ нэвтрүүлсэн байдал<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээний загварыг “Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журамд” нэмэлтээр оруулж, тээврийн хэрэгслийн гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.<br>**2-р улиралд:**<br>Тээврийн хэрэгслийн гэрчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.<br>**3-р улиралд:** | - | ТХБХ<br>МТХ | ТХБХ, МТХ: Авто тээврийн хэрэгслийн гэрчилгээг 2023 оны 9-р сарын 15-ны өдрөөс e-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн порталд байршууллаа. Ингэснээр иргэн, аж ахуй нэгж, байгууллагууд өөрийн өмчлөл, эзэмшлийн тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээг харах, шалгах мөн гэрчилгээгээ гээгдүүлсэн, үрэгдүүлсэн тохиолдолд цахим гэрчилгээг ашиглах боломжтой. Энэхүү цахим гэрчилгээ нь цаашид гар утасны аппликейшн ашиглан автотээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хийх суурь нөхцөл болох юм.<br>✓ Давуу тал:<br>✓ Биеэр ирэх шаардлагагүй<br>✓ Цаг хугацаа хэмнэнэ<br>✓ Зардал бууруулна<br>✓ Үйлчилгээний чанар хүртээмж дээшилнэ<br>✓ Үнэ төлбөргүй | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Цахим гэрчилгээг ашиглаж, цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. | | | ✓ Хөдлөх хөрөнгийн баталгаа болно<br>Гэрчилгээгээ гээгдүүлсэн, үрэгдүүлсэн тохиолдолд цахим гэрчилгээг ашиглах боломжтой. | |
| | 11.1.6 autobox автотээврийн цахим үйлчилгээний нэгдсэн платформыг хөгжүүлэх;<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд**<br>autobox.mn нэгдсэн порталын UI/UX дизайн боловсруулсан байна. /Зорилтот ажлын биелэлт 30%-доошгүй байна. /<br>**2-р улиралд**<br>autobox.mn нэгдсэн порталын хөгжүүлэлтийг хийж туршилт тохируулга хийсэн байна. /Зорилтот ажлын биелэл 70%-доошгүй байна./<br>**3- 4-р улиралд**<br>Системийг үйлчилгээнд бүрэн нэвтрүүлсэн байна. /Зорилтот ажлын биелэлт 100% байна. / | - | МТХ | Тус үйлдвэрийн газраас иргэдэд үзүүлж буй үйлчилгээг цахимжуулах чиглэлээр тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээ буюу хасалт, импортын бүртгэл, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, техник хяналтын үзлэгийн цаг захиалгын үйлчилгээ, хийцийн өөрчлөлтийн дүгнэлт гаргах үйлчилгээ, улс болон хот хоорондын зорчигч тээврийн тасалбар захиалга, мэргэшсэн жолоочийн цахим шалгалт зэрэг үйлчилгээнүүдийг www.autobox.mn цахим үйлчилгээний нэгдсэн платформыг боловсруулан ажиллаж байна. Системийн UI/UX дизайны ажил бүрэн хийж дууссан бөгөөд систем хөгжүүлэлтийн ажил бүрэн дууссан. 2023 оны 4-р улирлын байдлаар систем хөгжүүлэлтийн ажил хийгдэж ажлын явц 80%-ийн гүйцэтгэлтэй байна. | |
| | 11.1.7 autobox гар утасны апплекэйшнийг шинэчлэн хөгжүүлэх;<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-III улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд**<br>autobox аппликэйшны UI/UX дизайн боловсруулсан байна. /Зорилтот ажлын биелэлт 40%-доошгүй байна. /<br>**2-р улиралд**<br>autobox аппликэйшны хөгжүүлэлтийг хийж туршилт тохируулга хийсэн байна. /Зорилтот ажлын биелэлт 80%-доошгүй байна. /<br>**3-р улиралд**<br>Мобайл апп-ыг үйлчилгээнд бүрэн нэвтрүүлсэн байна. /Зорилтот ажлын биелэлт 100%-доошгүй байна. / | - | МТХ | Тус үйлдвэрийн газраас иргэдэд үзүүлж буй үйлчилгээг цахимжуулах чиглэлээр тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээ буюу хасалт, импортын бүртгэл, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн, техник хяналтын үзлэгийн цаг захиалгын үйлчилгээ, хийцийн өөрчлөлтийн дүгнэлт гаргах үйлчилгээ, улс болон хот хоорондын зорчигч тээврийн тасалбар захиалга, мэргэшсэн жолоочийн цахим шалгалт зэрэг үйлчилгээнүүдийг Андройд гар утсанд зориулагдсан хувилбар, IOS үйлдлийн системтэй гар утас зориулагдсан хувилбарыг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд хөгжүүлэлтийн ажил бүрэн дууссан. AUTOBOX апп бэлэн болсонтой холбогдуулан олон нийтэд сурталчлан таниулах хэвлэлийн хурал зохион байгуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2023 оны 12-р сарын 15-ний өдрөөс нийтэд хэвлэлийн хурлаар апп-ын танилцуулга шторк хийх, гар утасны апп-ын үйлчилгээ тус бүрээр мэдээлэл хүргэх, тоон гарын үсгийн хэрэглээ, үйлчилгээ цахимжуулснаар ямар боломжийг иргэдэд хүргэж буй талаар мэдээлэл хүргэх юм. Одоогоор апп-ын туршилт тохируулгын ажил хийгдэж байна. | |
| | 11.1.8 Тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дэвтрийг цахимжуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Цахим-Тад нэвтрүүлсэн байдал<br>**Хугацаа**<br>I-IV улирал | 20.0 сая.төг | АТХ<br>МТХ | Техник ашиглалтын дэвтрийг цахимжуулах ажлын даалгавар гаргасан. 2023 оны 2-р улирлаас систем хөгжүүлэлтийн UI/UX дезайны ажлыг эхлүүлэн систем хөгжүүлэлтийн шатанд хүргэн ажилласан. 2023 оны 3-р улирлаас ТАД-ын цахимжуулах систем хөгжүүлэлтийн төлөвлөгөө гарган ажиллаж байна. 2023 оны 4-р | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Техник ашиглалтын дэвтрийг цахимжуулах ажлын даалгавар гаргасан байна.<br>**2-р улиралд:**<br>Техник ашиглалтын дэвтрийг цахимжуулах программ хийнэ.<br>**3-р улиралд**:<br>Техник ашиглалтын дэвтрийг цахимжуулах программ туршина.<br>**4-р улиралд:**<br>Олон нийтэд сурталчилж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | | | улирлын байдлаар хөгжүүлэлтийн ажил 75%-гүйцэтгэлтэйгээр ажил явагдаж байна. | |
| | 11.1.9 Cube ERP системийн шинэчилсэн хувилбарыг нэвтрүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-II улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд**<br>Хүний нөөц, гүйцэтгэлийн төлөвлөгөө, Ажилтны үнэлгээний, Үүрэг даалгаврын модулийг хөгжүүлэх, Байгууллагын төлөвлөлтийг ЗСХНХ-тэй хамтран цахимжуулах /Зорилтот ажлын биелэлт 50%-доошгүй байна. /<br>**2-р улиралд**<br>Төлөвлөлт гүйцэтгэл, үүрэг даалгаврыг бүрэн цахимжуулсан байна. /Зорилтот ажлын биелэлт 100%-доошгүй байна / | - | МТХ | Cube ERP системийн шинэчилсэн хувилбарыг нэвтрүүлэх систем хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг гаргасан. Хүний нөөцийн бүртгэлийн модульд үе шаттайгаар хөгжүүлэлт хийж байна. Мөн түүнлчэн мэдээ, мэдээлэл ажилчдад хүртээмжтэй хүргэх байдлаар хөгжүүлэлтийг тухай бүр хийж байна. Ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг цахимаар оруулах хөгжүүлэлтийн ажил хийгдсэн ба явцын биелэлт оруулах тайлагналтын үе шатны хөгжүүлэлт хийгдэж байна. Эдгээр хөгжүүлэлтийн дараагаас үнэлгээ өгөх хөгжүүлэлтийн ажил хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| Зам, тээврийн салбарын үйлчилгээ, үйл ажиллагааг цахимжуулах дунд хугацаа (2020-2024)-ны дэд хөтөлбөрийн хүрээнд: | | | | | |
| 11.2 | 11.2.1 Байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэн, албан хэрэг хөтлөлтөд ашиглаж, тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог бүрэн хэмжээнд нэвтрүүлэх.<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Хэрэгжилтийн хувь<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:** Байгууллагынхаа удирдах ажилтан, албан хаагчдад тоон гарын үсгийн хэрэглээг бүрэн хэмжээнд нэвтрүүлж бусад ажилтан, албан хаагчдын тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлсэн байна.<br>**2-р улиралд:** Тоон гарын үсэг болон QR кодоор баталгаажуулсан цахим албан бичиг солилцоог нэвтрүүлсэн байна.<br>**3-4-р улиралд:** Тоон гарын үсгийн хэрэглээг албан хэрэг хөтлөлтөд 100% ашигласан байна. | Улсын төсөв, дотоодын эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | МТХ | 2022.11.01-ний өдрөөс "Үндэсний Дата Төв" УТҮГ- нь Цахим гарын үсгийн тухай хуулийн 34-р зүйл, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын А/28 дугаар тушаал болон Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгохгүй болсон. Иймд цаашид үйлдвэрийн газар нь Үндэсний дата төвөөс тоон гарын үсэг шинээр авах болон сунгалт хийх боломжгүй болсон. Үндэсний дата төвөөс өгсөн зөвлөмжийн дагуу 2023 оны 1-р улирлын байдлаар "Тридиум и-Секюрити" ХХК-ийн тоон гарын үсгийг сонгон 8 тоон гарын үсгийг тус үйлдвэрийн газрын удирдлага, албан хаагчдад авч өгсөн. Мөн тухайн шинэ тоон гарын үсгийг ашиглах заавар зөвлөгөөг өгч, практик сургалт явуулж ажилласан.<br>Бусад байгууллагууд руу тоон гарын үсгээр баталгаажуулсан албан бичиг солилцох боломжийг бүрдүүлсэн.<br>Тус үйлдвэрийн газраас шинээр үйлчилгээнд гаргаж буй AUTOBOX гар утасны аппликейшнд GSign тоон гарын үсгийн технологийг нэвтрүүлж, иргэдээс ирэх цахим хүсэлтийг баталгаажуулах, цахим технологийг нэвтрүүлсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Иргэд өөрийн өмчлөлийн тээврийн хэрэгслийг бусдад шилжүүлэх үйлчилгээг Төрийн ТҮЦ машинаар авах боломжийг EMongolia, Үндэсний Дата Төв зэрэг төрийн байгууллагуудтай хамтарч нэвтрүүллээ. Уг үйлчилгээг нэвтрүүлэхэд Иргэний үнэмлэх болон Иргэний гар утас ашиглан тоон гарын үсэг зурах технологийг нэвтрүүлсэн. | |
| **Зорилт 12: Үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагааг хэвийн жигд явуулж, тогтвортой байдлыг хангана** | | | | | |
| Үйлдвэрийн газрын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт , зорилтот түвшинг хангаж биелүүлэх, орлого төвлөрүүлж, зардлыг зориулалтын дагуу зарцуулах чиглэлээр | | | | | |
| 12.1 | 12.1.1 2023 оны улирал бүрийн баланс тайлан гаргах, холбогдох дээд байгууллагуудад хүргүүлэх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тайлан баланс гарч, холбогдох байгууллагад хүргүүлсэн байдал<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>2022 оны жилийн эцсийн тайлан балансыг нэгтгэн гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна**.**<br>**2-р улиралд:**<br>2023 оны 1 болон 2-р улирлын тайлан балансыг нэгтгэн гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.<br>**3-р улиралд:**<br>2023 оны 3-р улирлын тайлан балансыг нэгтгэн гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.<br>**4-р улиралд:**<br>2023 оны 4-р улирлын тайлан балансыг нэгтгэн гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна. | - | СЭЗХ | 2022 оны жилийн эцсийн тайлан балансыг нэгтгэн гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.<br>2023 оны 2-р улирлын тайлан балансыг нэгтгэн гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан болно.<br>2023 оны 3-р улиралын тайлан баланс нэгтгэн гаргаж Гэрэлтэх бүртгэл аудит ХХК-д хүргүүлэн явцын аудитад холбогдох шаардлагатай мэдээллүүдийг гарган өгч хамтран ажиллаж байна.<br>2023 оны 4-р улиралын тайлан баланс гарах хугацаа болоогүй байгаа тул бэлтгэл ажил хангагдан данс бүртгэл хянан ажиллаж байна | |
| | 12.1.2 Үйлдвэрийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Аудитын зөвлөмжийн хэрэгжилт<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Аудитын зөвлөмжийн дагуу төлөвлөгөө боловсруулсан байна.<br>**2-3-р улиралд:**<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлж, ажилласан байна.<br>**4-р улиралд:** | - | СЭЗХ | 2022 оны Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтээр үйлдвэрийн газрын хэмжээнд 33 зөвлөмж, 18 албан шаардлага, акт 4 ийг авч ажилласны дагуу төлөвлөгөө гарган 2023.04.05-ны өдөр захирлаар батлуулан салбар төв, хариуцах албан тушаалтанд хүргүүлэн ажилласан. 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 3/1121 тоот албан бичгээр Үндэсний аудит, ТӨБЗГ, ЗТХЯ-нд биелэлтийг нэгтгэн хүргүүлэн ажилласан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Аудитын зөвлөмжийн биелэлтийг холбогдох газарт хүргүүлсэн байна. | | | | |
| | 12.1.3 Үндсэн хөрөнгө, бараа материал, маягт, үнэт цаасны тооллого хийх ажлыг зохион байгуулах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Тооллогын ажлын хэрэгжилт<br>**Хугацаа**<br>II,IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**2-р улиралд:**<br>Үйлдвэрийн газрын 2023 оны эхний хагас жилийн тооллогын ажлыг зохион байгуулсан байна.<br>**4-р улиралд:**<br>Үйлдвэрийн газрын 2023 оны  жилийн эцсийн тооллогын ажлыг зохион байгуулсан байна | - | СЭЗХ | 2023 оны хагас жилийн бараа материалын тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийн захирлын 2023 оны 06 сарын 15-ны өдрийн А/141 тушаалаар байгуулсан.<br>Тооллогын комисс нь 2023 оны 06 сарын 20-ны өдрөөс 06 сарын 30–ны өдрийг дуустал төв албаны бараа материалыг газар дээр нь үзэж, санхүүгийн бүртгэлтэй тулгалт хийж тоолсон. Аймаг, нийслэлийн салбар төвүүд өөрийн салбартаа ажлын хэсэг байгуулан 2023 оны хагас жилийн бараа материалын тооллогыг хийж төв албанд тооллогын материалыг ирүүлсэн. Ажлын хэсэг аймаг, нийслэлийн салбар төвүүдийн бараа материалын тооллогын тайланг 07 сарын 09-ны өдрийг дуустал хугацаанд нэгтгэн гаргасан.<br>Нэгтгэлээр нийт 29 салбар, төвийн тооллогын бүртгэлийг нэгтгэхэд 2,115.3 сая төгрөгийн /Үүнд 478.5 сая төгрөгийн маягт, үнэт цаас, 1,636.8 сая төгрөгийн бараа материал/ үнэ бүхий 10,964,189 ширхэг маягт үнэт цаас, бараа материал тоолохоос 2,115.3 сая төгрөгийн үнэ бүхий 10,964,189 ширхэг маягт үнэт цаас, бараа материалыг тус тус тоолсон байна. Тооллогын комисс:<br>1. Үйлдвэрийн газрын хэмжээнд актлах шаардлагатай 2-оос 10 жилийн насжилттай ашиглалтын хугацаа дууссан 78 нэрийн 161 ширхэг 29.7 сая төгрөгийн үнэ бүхий бараа материал, мөн ашиглалтаас гарсан цаашид ашиглахгүй, үйлдвэрийн болон хэвлэлийн алдаатай сери алгасаж хэвлэгдсэн гэх мэт тайлбар бүхий нийт 0.1 сая төгрөгийн үнэ бүхий 4849 ширхэг маягт, үнэт цаасыг тус тус актлах<br>2. Эд хариуцагч нарын /онцгойлон салбар төвүүдийн эд хариуцагч/ эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах санал гаргасан байна.<br><br>2023 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг зохион байгуулах ажлын хэсэг 12 сарын 11-ний өдрийн А/254 дугаар тушаалаар байгуулагдсан. | |
| | 12.1.4 Үйлдвэрийн газрын 2023 оны орлого, зардлын төлөвлөгөөг салбар нэгж, нэр төрөл тус бүрээр төлөвлөн гаргаж, батлуулах, биелэлтийг хангаж ажиллах<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Биелэлт хангагдсан байдал<br>**Хугацаа** | - | СЭЗХ | 2023 оны үйлдвэрийн газрын нийт орлогын төлөвлөгөөг салбар, төв, сар, улирал, жилээр каленьдарчилсан төлөвлөгөөг хийн 01 дүгээр сарын 18-ны өдөр захирлаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Зардлын төлөвлөгөөг 04 дүгээр сарын 26-ны өдөр салбар, төвөөр, сар улирлаар батлуулан хүргүүлж хэрэгжилтийг хانган ажиллаж байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-р улиралд:**<br>Орлого, зардлыг төлөвлөн гаргаж, захирлаар батлуулсан байна.<br>**2-4-р улиралд:**<br>Биелэлтийг хангуулан ажилласан байна | | | | |
| | 12.1.5 Үйлдвэрийн газрын салбар төвүүдээс 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгах орлого, зардлын төлөвлөгөөг авч нэгтгэн ТӨБЗГ-т хүргүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулан ажиллах.<br>**Шалгуур үзүүлэлт**<br>ТӨБЗГ-т хүргүүлсэн байдал<br>**Хугацаа**<br>IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**4-р улиралд:**<br>Үйлдвэрийн газрын 2023 оны эдийн зэсгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгах орлого зардлын төлөвлөгөөг нэгтгэж, ТӨБЗГ-т хүргүүлсэн байна. | - | СЭЗХ | Үйлдвэрийн газрын салбар төвүүдээс 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгах орлого, зардал, хөрөнгө оруулалт худалдан авалтын төлөвлөгөө 06 дугаар сарын 30-ны өдрөөр нэгтгэн авч боловсруулсан. Боловсруулсан 2024 оны зорилтот түвшиний урьдчилсан саналыг хуулийн хугацаанд буюу 07 дугаар сарын 31-ний өдрийн 1/1036 тоот, 11 сарын 20-ны өдрийн 1/1502 тоот албан бичгээр тус тус ТӨБЗГ-т хүргүүлсэн. | |
| | 12.1.6 Автомашины улсын дугаарын дуудлага худалдааг зохион байгуулахтай холбоотой санхүүгийн тооцооллыг хийх<br>**Шалгуур үзүүлэлт**<br>Дуудлага худалдаанаас олсон орлого Засгийн газрын тусгай санд төвлөрсөн байдал<br>**Хугацаа**<br>I-IV улирал<br>**Зорилтот түвшин**<br>**1-4-р улирал:**<br>Санхүүгийн тайланд тусгаж, дуудлага худалдаанаас олсон орлогыг Засгийн газрын тусгай санд төвлөрүүлнэ. Тухай бүрд дэнчингийн мөнгийг буцаасан байна. | - | СЭЗХ | Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020.11.18-ны өдрийн А/222 дугаар тушаалаар “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг шинэчлэн баталсан. Үүнтэй холбогдуулан “АТҮТ” ТӨҮГ-ын захирлын 2020.12.08-ны өдрийн А/287 дугаар тушаалаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг дуудлага худалдаагаар зохион байгуулах удирдамж”- ийн дагуу тус үйлдвэрийн газрын дуудлага худалдааны дансанд 4 дүгээр улирлын байдлаар тээврийн хэрэгслийн улсын дугаарын 3400 ширхэг дугаарын 5,6 тэрбум төгрөгний орлого төвлөрүүлж, буцаалт хийгдэх 8000 иргэний 4,5 тэрбум төгрөгийн дэнчинг буцаан олгосон ба 3,150,0 сая төгрөгийг “Хүүхдийн төлөө” тусгай санд шилжүүлсэн. Тээврийн хэрэгслийн улсын дугаарын дуудлага худалдааны мэдээллийг өдөр бүр 09.00,14.00, 16.00 цагт тайлагнаж ажилласан. | |

Үйлдвэрийн газар нь 2023 онд 12 зорилт, 24 чиглэлийн хүрээнд нийт 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ